



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 6 сарын 26 өдөр

Дугаар А-98

Улаанбаатар хот

Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг үнэлэх “Үнэлгээний аргачлал” батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны А-101 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг үнэлэх “Үнэлгээний аргачлал” баримт бичгийг хавсралгаар баталсугай.


2. Энэхүү баримт бичгийн дагуу үнэлгээ хийж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 0927



ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү үнэлгээний аргачлалын зорилго нь Олон улсын төлбөр тооцооны банк болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан "Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчим"-ын хэрэгжилт үнэт цаасны төлбөр тооцооны системийн хэмжээнд хангагдаж байгаа эсэхийг тодорхойлох, хэрэгжилтийн түвшинг ахиулах, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 1.2. Үнэлгээчин нь энэхүү аргачлалын дагуу үнэлгээ хийхдээ тухайн системийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлуудыг олж тогтоон, зөрчил, дутагдлыг засаж залруулах талаар санал, зөвлөмж боловсруулж, холбогдох зарчмуудын хэрэгжилтийн түвшинг тогтоон, үнэлгээ өгнө.

Хоёр. Үнэлгээний урьдчилсан нөхцөл

- 2.1. Үнэлгээчин нь үнэлгээ хийхэдээ шаардлагатай мэдээллийг авах, холбогдох албан тушаалтнуудтай уулзах боломжоор бүрэн хангагдсан байх шаардлагатай.
- 2.2. Тухайн төлбөр тооцооны систем нь найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллах бодит туршлага, нөөц бололцоотой эсэхэд онцгой ач холбогдол өгөхийн зэрэгцээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж буй арга замыг нь үнэлэх шаардлагатай.
- 2.3. Үнэлгээчин нь үнэлгээ хийх хангалттай мэдлэг, боловсрол, ажлын туршлагатай байхын зэрэгцээ тухайн төлбөр тооцооны системийн талаар гүн ойлголттой байх шаардлагатай.
- 2.4. Үнэлгээ нь төлбөр тооцооны систем бүрийн хувьд харилцан адилгүй байж болох тул тухайн системийн үйл ажиллагааны аль хэсэгтэй холбоотой үнэлгээ хийх гэж байгааг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Гурав. Үнэлгээ хийх үе шат

- 3.1. Зарчмуудын хэрэгжилтийг дараах үе шатаар үнэлнэ:
 1. Үнэлгээний цар хүрээг тодорхойлох;
 2. Гол асуудал бүрийн талаар мэдээлэл цуглуулах;
 3. Зарчим бүрийн дагуу дүгнэлт гаргах;

4. Зарчим бүрийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх;
5. Зөрчил, дутагдлыг засаж залруулах цаг хугацааг тогтоох;
6. Үнэлгээний тайлан боловсруулж, тайлагнах.

Үе шат 1. Үнэлгээний цар хүрээг тодорхойлох

- 3.2. Үнэлгээчин нь үнэлгээний цар хүрээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Үнэлгээний цар хүрээг тодорхойлохдоо тухайн системийн ямар үйл ажиллагаа, үйлчилгээг аль зарчмын дагуу үнэлэх талаар тодорхой заана.
- 3.3. Үнэлгээчин нь үнэлгээний цар хүрээг нарийвчлан тодорхойлохын тулд тухайн төлбөр тооцооны системийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар гүн ойлголттой байна.
- 3.4. Хэрэв хэд хэдэн системийг хамарсан үнэлгээ хийх гэж байгаа бол систем бүрийг тусад нь үнэлнэ. Үнэлгээнд хамрагдаж буй систем нь хил дамнасан төлбөр тооцоо боловсруулдаг тохиолдолд холбогдох улс орны эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж болно.
- 3.5. Үнэлгээг холбогдох зарчим бүрийн дагуу дараах байдлаар хийж болно:
 1. Тухайн төлбөр тооцооны системийн үйл ажиллагааны найдвартай, үр ашигтай байдалд хийх иж бүрэн хяналт хэлбэрээр;
 2. Шинээр нэвтрүүлж буй үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд гарч буй томоохон өөрчлөлт, шинэчлэлтэй холбогдуулан;
 3. Хэд хэдэн системийг хамарсан тодорхой асуудалд чиглэгдсэн хяналт, шалгалттай холбогдуулан;
 4. Өмнө нь олж тогтоогдсон зөрчил, дутагдал, тодорхой асуудлын хүрээнд.

Үе шат 2. Гол асуудал бүрийн талаар мэдээлэл цуглуулах

- 3.6. Холбогдох зарчим бүрийн хэрэгжилтийг дүгнэхийн тулд үнэлгээчин нь Хавсралт 2-т оруулсан үнэлгээний асуулга болон тухайн системийн онцлогтой холбоотой нэмэлт асуулт тавих замаар хангалттай мэдээлэл цуглуулна. Үнэлгээчний хувьд эдгээр асуулт нь тухайн системд зарчмуудын хэрэгжилт хэрхэн хангагдаж буйг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл болох юм.
- 3.7. Үнэлгээчний тавьж буй асуулт ерөнхийдөө эрсдэл хамгийн ихтэй асуудалд чиглэх нь зүйтэй. Үнэлгээний үр дүнд онцгой ач холбогдол үзүүлэх эрсдэлийн хүчин зүйлс, нөхцөл байдлыг тусган харуулах зорилгоор асуултыг тухайн системийн онцлогт нийцүүлэн өөрчлөн тавих боломжтой.
- 3.8. Дүгнэлт гаргаж, үнэлгээ өгөхийн тулд үнэлгээчин нь тухайн системийн үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ, дүрэм, журмын талаар сайтар ойлголттой байх шаардлагатай. Тиймээс үнэлгээчин нь үнэлгээ хийж байхдаа дараах асуудалд байнга анхаарал хандуулах нь зүйтэй:
 1. Тухайн зарчмыг ямар арга хэрэгслээр хэрэгжүүлж байна вэ?

2. Тухайн зарчмыг хэрэгжүүлж буй арга хэрэгслийн үр дүнтэй байдлыг хангах ямар дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авч байна вэ?
3. Тухайн зарчмын хэрэгжилтийг хэрхэн хэмжиж, хяналт тавьж байна вэ?
4. Тухайн зарчмыг хэрэгжүүлж байгааг хянах ямар баримт нотолгоо байна вэ?

Үе шат 3. Зарчим бүрийн дагуу дүгнэлт гаргах

3.9. Дүгнэлт нь үнэлгээчний үнэлж буй төлбөр тооцооны систем тухайн зарчмыг хэр зэрэг хэрэгжүүлж буйг тодорхойлох ерөнхий үзүүлэлт болно. Үнэлгээчин нь дүгнэлтээ холбогдох зарчим бүрийн дагуу цуглуулсан баримт мэдээлэл дээрээ үндэслэн хураангуй хэлбэрээр гаргана. Дүгнэлт гаргахдаа:

1. Тухайн төлбөр тооцооны системийн туршлага, ололт амжилтыг баримт нотолгоонд үндэслэн товч дүгнэх;
2. Цуглуулсан баримт мэдээлэлдээ тулгуурлан аливаа зөрчил, дутагдлыг олж тогтоох;
3. Илэрсэн зөрчил, дутагдал бүртэй холбогдуулан тухайн зарчмын хэрэгжилтийг хангахад тулгарч болох эрсдэл, бусад асуудлын талаар тайлбар хийх;
4. Тэдгээр эрсдэл, холбогдох асуудлыг үндэслэн тухайн зөрчил, дутагдал нь анхаарвал зохих асуудал мөн эсэхийг тодорхойлох. Анхаарвал зохих асуудлыг 3 төрөлд авч үзнэ:
 - Ноцтой, нэн даруй анхаарал хандуулах асуудал;
 - Нэн даруй шийдвэрлэхгүй бол ноцтой түвшинд хүрч болохуйц асуудал;
 - Тогтоосон цаг хугацаанд багтаан шийдвэрлэх асуудал.

3.10. Дүгнэлт нь Үе шат 4-т тайлбарласан үнэлгээг өгөх үндэслэл болно.

Үе шат 4. Зарчим бүрийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх

3.11. Үнэлгээг зарчим бүрийн хэрэгжилтийн түвшинтэй уялдуулж, илэрсэн зөрчил, дутагдал, тэдгээрийг засаж залруулахад шаардлагатай цаг хугацааг харгалзан өгнө.

3.12. Зарчим бүрийн хэрэгжилтийн түвшинд дараах үнэлгээг өгнө.

Үнэлгээ	Шалтгаан
Хэрэгжсэн	Илэрсэн зөрчил, дутагдал нь анхаарал шууд хандуулахуйц томоохон асуудал биш бөгөөд хэвийн үйл ажиллагааны явцад шийдвэрлэх боломжтой.
Ерөнхийдөө хэрэгжсэн	Тогтоосон хугацаанд багтаан шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг авах шаардлагатай зөрчил, дутагдал илэрсэн.
Хэсэгчлэн хэрэгжсэн	Нэн даруй шийдвэрлэхгүй бол ноцтой асуудалд хүргэж болохуйц зөрчил, дутагдлыг олж тогтоосон ба тэдгээр асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдол өгөх шаардлагатай.
Хэрэгжээгүй	Нэн даруй арга хэмжээ авч шийдвэрлэх шаардлагатай ноцтой зөрчил, дутагдал илэрсэн бөгөөд тэдгээр асуудлыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдол өгөх шаардлагатай.

Хамааралгүй	Хууль тогтоомжийн зохицуулалт, бүтэц, зохион байгуулалтын зэрэг хүчин зүйлээс шалтгаалан тухайн зарчмыг хэрэгжүүлэх шаардлагагүй.
--------------------	---

- 3.13. Үнэлгээ нь дүгнэлтэд үндэслэсэн байх ба илэрсэн зөрчил, дутагдал бүртэй холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэл, түүний үр дагавар, түүнчлэн үнэлгээчний бусад асуудлын талаарх саналыг тусгасан байна. Шаардлагатай тохиолдолд үнэлгээний тайланд засаж, сайжруулах зорилгоор хийх ажлын төлөвлөгөөний талаар дурдаж болно.
- 3.14. Тухайн зарчмын хэрэгжилтэд нарийвчилсан үнэлгээ хийх боломжгүй тохиолдолд энэ талаар үнэлгээний тайланд дурдаж, холбогдох тайлбарыг хийнэ. Жишээлбэл, тодорхой мэдээллийг олж авч чадаагүй эсхүл холбогдох албан тушаалтантай уулзах боломж олдоогүй тохиолдолд тайлбарыг оруулна.
- 3.15. Мэдээлэл авах, уулзалт зохион байгуулах хүсэлт гаргахад үл тоомсорлох хэлбэрээр хандсан бол үүнийг бичгээр баримтжуулах нь зүйтэй бөгөөд асуудалд хэрхэн хандсаныг харуулах баримт нотолгоо болгон ашиглах боломжтой.
- 3.16. Тухайн зарчмын хэрэгжилтийг үнэлэхдээ нэн түрүүнд түүнийг хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлно. Учир нь үнэлүүлж буй төлбөр тооцооны системд тухайн зарчим нь хамаарах боловч хууль тогтоомжийн зохицуулалт, үйл ажиллагааны онцлог зэргээс шалтгаалан түүнийг хэрэгжүүлэх шаардлагагүй байх тохиолдол үүсдэг. Жишээлбэл, оролцогчдод өдрийн зээл олгох механизмгүй төлбөр тооцооны системийн хувьд зээлийн эрсдэлийн тухай Зарчим 4 хамаарахгүй.
- 3.17. Хэрэгжүүлэх зарчим бүртэй холбоотойгоор илэрсэн аливаа зөрчил, дутагдал нь анхаарал татахуйц томоохон асуудал биш байхын зэрэгцээ систем нь хэвийн үйл ажиллагааныхаа явцад шийдвэрлэж болохоор байвал зарчмыг хэрэгжсэн гэж үнэлж болно. Тухайн зарчмын хэрэгжилт бүрэн хангагдаагүй тохиолдолд үнэлгээчин нь хэрэгжилтийн түвшинг зайлшгүй тодорхойлно. Илэрсэн зөрчил, дутагдлын тоо хэмжээний үзүүлэлтээс гадна тэдгээрийн үр дагаврыг харгалзан үнэлгээ өгнө. Тухайн зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор илэрсэн хамгийн ноцтой зөрчил, дутагдлыг үнэлгээнд тусгах шаардлагатай.
- 3.18. Зарим тохиолдолд олон тооны жижгэвтэр зөрчил, дутагдал нь бүхэлдээ анхаарвал зохих асуудлыг бий болгох талтай тул үнэлгээнд тухайн үеийн нөхцөл байдлыг бодитоор тусгах шаардлагатай.

Үе шат 5. Илэрсэн зөрчил, дутагдлыг засаж залруулах хугацааг тогтоох

- 3.19. Илэрсэн зөрчил, дутагдал, тэдгээрийг шийдвэрлэх хугацааг үнэлгээний тайланд зааж өгнө. Тухайн зарчмыг "Хэрэгжсэн" гэж үнэлээгүй бол үнэлгээчин нь анхаарвал зохих асуудлыг шийдвэрлэж, хэрэгжилтийн түвшинг ахиулах талаар зөвлөмж өгөх шаардлагатай.

- 3.20. Зарчмууд нь цогцоороо тухайн системийн найдвартай, үр ашигтай байдалд дэмжлэг үзүүлдэг тул зарчим нэг бүрээр ач холбогдлын түвшин тогтоодоггүй болно. Иймээс үнэлгээчин нь тухайн системийн ил тод, үр ашигтай байдалд хамгийн их эрсдэл учруулж болзошгүй зөрчил, дутагдлуудын талаарх санал бодолдоо үндэслэсэн тохиромжтой хугацааг тогтооно.
- 3.21. Шаардлагатай тохиолдолд үнэлгээчин нь зайлшгүй анхаарах асуудал болж хөндөгдөөгүй бусад зөрчил, дутагдлыг засаж залруулах талаар тодорхой хугацаа заагаагүй зөвлөмж өгөх ба төлбөр тооцооны систем нь хэвийн үйл ажиллагааныхаа явцад тэдгээрт анхаарал хандуулбал зохино.

Үе шат 6. Үнэлгээний тайлан боловсруулж, тайлагнах

- 3.22. Үнэлгээчин нь үнэлгээний зорилго, цар хүрээ, үйл явц, үр дүн, бусад холбогдох асуудлын талаар Хавсралт 1-т заасан ерөнхий загварын дагуу үнэлгээний тайлан бэлтгэж, удирдлагад танилцуулна.

_____оОо_____

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ЗАГВАР

I. Хураангуй

Энэ хэсэгт үнэлгээний үр дүнг онцлон тусгана.

II. Удиртгал

Энэ хэсэгт тайлангийн танилцуулга болон үнэлгээтэй холбогдсон дараах гол мэдээллийг оруулна.

- **Үнэлгээчин:** Үнэлгээчнийг дурдах.
- **Үнэлгээний зорилго:** Үнэлгээний зорилгыг тодорхойлох.
- **Үнэлгээний цар хүрээ:** Үнэлгээнд орсон төлбөр тооцооны систем, түүний үйл ажиллагаа, үйлчилгээ, хэрэгжилтийг нь үнэлсэн зарчмуудыг дурдах.
- **Үнэлгээний аргачлал:** Үнэлгээний үе шатуудыг дурдах. Бүх зарчмын хэрэгжилтийг үнэлээгүй тохиолдолд үнэлэгдээгүй зарчмын талаар тайлбар хийх.
- **Үнэлгээнд ашиглагдсан мэдээллийн эх сурвалж:** Үнэлгээнд ашигласан олон нийтэд нээлттэй болон хаалттай мэдээллийн үндсэн эх сурвалжуудыг дурдах. Эдгээр эх сурвалж нь баримт бичиг (өөр бусад үнэлгээ, судалгаа, асуулга, тайлан, шинжилгээ, холбогдох хууль, журам, зохицуулалтын болон салбарын удирдамж гэх мэт)-ийн хэлбэрээр болон тухайн төлбөр тооцооны систем, түүний оролцогчид, эрх бүхий албан тушаалтантай хийсэн ярилцлагын хэлбэрээр байж болно

Түүнчлэн, энэ хэсэгт үнэлгээний явц, цар хүрээг явцуу болгоход хүргэсэн мэдээлэл, хамтын ажиллагааны дутмаг байдал зэрэг үнэлгээ хийхэд тулгарсан аливаа хүндрэл бэрхшээлийн талаар дурдана. Цаашлаад, мэдээлэл авах хүсэлт гаргасан боловч тухайн мэдээллийг өгөөгүй бол холбогдох тайлбарыг хийнэ.

III. Төлбөр тооцооны системийн ерөнхий дүр зураг

Энэ хэсэгт нийт төлбөрийн системд тухайн төлбөр тооцооны системийн гүйцэтгэж буй үүрэг оролцоо, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх ерөнхий мэдээлэл болон үйл ажиллагааных нь цар хүрээг илтгэх статистик мэдээллийг тусгана.

Түүнчлэн, энэ хэсэгт тухайн төлбөр тооцооны системтэй холбоотой хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо, холбогдох эрх бүхий байгууллагуудын санал, дүгнэлт, сүүлийн үед хийгдсэн болон ойрын ирээдүйд төлөвлөгдөөд буй томоохон өөрчлөлт, шинэчлэлтийн талаар дурдана.

IV. Үнэлгээний хураангуй

Энэ хэсэгт зарчмуудын хэрэгжилтэд хийсэн үнэлгээний нарийвчилсан үр дүнг нэгтгэн дүгнэнэ. Холбогдох зарчим бүрийн хувьд үнэлгээгээр:

- тухайн төлбөр тооцооны системийн туршлага, ололт амжилтыг онцлох;
- анхаарвал зохих асуудлыг жагсаан дурдах;
- хэрэгжилт нь бүрэн хангагдаагүй зарчим бүрт тайлбар өгч, "ерөнхийдөө хэрэгжсэн", "хэсэгчлэн хэрэгжсэн", "хэрэгжээгүй" гэсэн үнэлгээ өгсөн гол шалтгаан болон хэрэгжилтэд нөлөөлсөн байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг дурдах шаардлагатай. Мөн анхаарвал зохих асуудлууд шийдвэрлэгдэж буй эсэх болон одоо авч буй арга хэмжээг төлөвлөсний дагуу үргэлжлүүлснээр хүрэх хэрэгжилтийн түвшинг тодорхойлно.

Зарчим нэг бүрийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнг энэ хэсэгт нэгтгэн дүгнэнэ. (Хүснэгт 1-ийг харна уу)

Хүснэгт 1 Үнэлгээний нэгтгэл	
Үнэлгээний хэлбэр	Зарчим
Хэрэгжсэн	<i>Жишээлбэл: Зарчим 1,3,6 болон 8</i>
Ерөнхийдөө хэрэгжсэн	
Хэсэгчлэн хэрэгжсэн	
Хэрэгжээгүй	
Хамааралгүй	

Зөвлөмж

Энэ хэсэгт тухайн зарчмын хэрэгжилтийг ахиулах үүднээс авч болох арга хэмжээг дурдана. Хүснэгт 2-т зарчмуудын хэрэгжилттэй холбоотойгоор анхаарвал зохих асуудлууд, бусад зөрчил, дутагдал, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх зөвлөмжүүд болон холбогдох арга хэмжээг авах цаг хугацааг дурдана.

Үнэлгээчин нь зөвлөмжүүдийг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатайгаас нь эхлэн ач холбогдлоор нь жагсаана. Түүнчлэн, тухайн зөвлөмжийг хэрэгжүүлснээр тухайн зарчмын хэрэгжилтийн түвшин хэрхэн ахих талаар тайлбарлах нь зүйтэй. Хэрэв тухайн төлбөр тооцооны систем нь хэрэгжилтийн түвшингээ ахиулах тодорхой төлөвлөгөөтэй байгаа бол энэ талаар тайлбар хэсэгт оруулах хэрэгтэй. Мөн хэрэгжилт хангахад тулгарч буй аливаа хүндрэл бэрхшээлийг дурдана.

Хүснэгт 2. Зөвлөмж (ач холбогдлоор нь жагсаах)			
Зарчим	Анхаарах асуудал, бусад зөрчил, дутагдал	Зөвлөмж, тайлбар	Зөвлөмжийг авч хэрэгжүүлэх цаг хугацаа

V. Нарийвчилсан үнэлгээний тайлан

Нарийвчилсан үнэлгээний хүснэгтэд холбогдох зарчим бүрт хамаарах гол асуудал, дүгнэлт болон өгсөн үнэлгээний талаарх тайлбарыг хийнэ. (Хүснэгт 3-ыг харна уу)

Хүснэгт 3	
Зарчмын хэрэгжилтэд хийсэн нарийвчилсан үнэлгээ	
<i>Холбогдох зарчим бүрийн хувьд</i>	
Зарчим: Х	
Агуулга	
Гол асуудал 1 Агуулга	Энэ хэсэгт тухайн төлбөр тооцооны системийн хуримтлуулсан практик туршлагын талаарх мэдээллийг тухайн гол асуудалтай нь холбон тусгана. Үнэлгээчин нь холбогдох гол асуудал бүрээр үнэлгээний асуулгын дагуу асуулт тавьж мэдээлэл цуглуулна. Зөвхөн үнэлгээнд орж буй тухайн төлбөр тооцооны системд хамаарах гол асуудлуудыг сонгох хэрэгтэй. Хариултуудад тухайн төлбөр тооцооны системийн оператор болон оролцогчдын бодит туршлагыг тусгасан байх ёстой. Үнэлгээний асуулгын дагуу цуглуулсан мэдээллийг үнэлгээний тайланд бүхэлд нь оруулах шаардлагагүй болно.
Гол асуудал ... Агуулга	Мэдээлэл ...
Дүгнэлт	Энэ хэсэг холбогдох гол асуудал бүрийн хүрээнд олж авсан баримт мэдээлэлд үндэслэн зарчим бүрийн талаар цуглуулсан үндсэн мэдээллийг товч дурдана. Ингэхдээ тухайн төлбөр тооцооны системийн туршлага, ололт, амжилт болон анхаарвал зохих асуудлуудын ач холбогдол, бусад зөрчил дутагдлын талаар дурдах шаардлагатай.
Зарчмын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ	Энэ хэсэгт тухайн зарчим нь "хэрэгжсэн", "ерөнхийдөө хэрэгжсэн", "хэсэгчлэн хэрэгжсэн", "хэрэгжээгүй", "хамааралгүй" эсэхийг дурдана. Мөн тухайн өгсөн үнэлгээний үндэслэлийг дурдана.
Зөвлөмж, тайлбар	Энэ хэсэгт анхаарвал зохих асуудал, бусад зөрчил, дутагдал бүрийн дагуу авах зөвлөмж, тайлбарыг тусгана.

ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА

Зарчим 1. Эрх зүйн зохицуулалт

Дэд бүтцийн үйл ажиллагаа нь эрх зүйн тодорхой, ил тод, хэрэгжихүйц зохицуулалттай байх.

Гол асуудал 1. Үйл ажиллагааныхаа эрх зүйн зохицуулалтыг маш тодорхой болгох.

Үндсэн үйл ажиллагаа

1.1.1 Эрх зүйн маш тодорхой зохицуулалт шаардсан ямар үндсэн үйл ажиллагаа явуулж байна вэ?

1.1.2 Ямар улс оронд үндсэн үйл ажиллагаагаа явуулж байна вэ?

Үндсэн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

1.1.3 Үйл ажиллагааныхаа эрх зүйн зохицуулалт (өөрөөр хэлбэл, эрх зүйн тогтолцоо, дүрэм, журам, гэрээ)-ыг тодорхой эсэхийг хэрхэн нягталдаг вэ?

- а. ҮЦТХТ нь биет үнэт цаасыг цахим хэлбэрээр бүртгэх, цахим хэлбэрт оруулах болон эзэмшигчийн дансны бүртгэлд үндэслэн шилжүүлэхийг хууль эрх зүйн талаас хэрхэн бүрдүүлсэн вэ?
- б. АКТ нь АКТ-ийн үйл ажиллагааг эрхлэх хууль, эрх зүйн үндэслэлийг хэрхэн хангасан бэ? Тухайлбал, гэрээг шинэчлэн орлуулах, үнэт цаасыг хоёрдогч зах зээлийн ханшаас доогуур санал болгох зэрэг хууль, эрх зүйн арга хэрэгсэлд хэр зэрэг анхаарал хандуулсан бэ? АКТ нь гэрээг шинэчлэн орлуулах, үнэт цаасыг хоёрдогч зах зээлийн ханшаас доогуур санал болгох зэрэг хууль, эрх зүйн арга хэрэгслийг ашиглахаас татгалзсан, эсвэл өөрчлөгдсөн эсэх талаар мэдээлдэг үү? Хэрэв тийм бол ямар нөхцөлд энэ талаар мэдээлдэг вэ?
- в. АМС нь хадгалж буй тайлан мэдээллийг хууль, эрх зүйн талаас хэрхэн хамгаалдаг вэ? Холбогдох этгээдийн мэдээлэлд хандах, нууцлалыг хадгалах, мэдээллийг задруулахтай холбоотой эрхийг хууль, эрх зүйн талаас хэрхэн тодорхойлсон бэ?
- г. Дэд бүтэц нь нэгтгэн цэвэршүүлж үр дүнгийн тооцоолол хийдэг бол энэ зохицуулалтыг дэмжсэн хууль, эрх зүйн үндэслэлийг хэрхэн хангасан вэ?
- д. Дэд бүтцээр хийгдэж буй төлбөр тооцоог эцэслэхтэй холбоотойгоор гүйлгээний (мөн төлбөрийн чадваргүй болсон оролцогчийн гүйлгээг оролцуулан) эцсийн байхыг дэмжсэн хууль, эрх зүйн зохицуулалтыг хэрхэн бүрдүүлсэн вэ? Хөрөнгө шилжүүлгийн систем, үнэт цаасны шилжүүлгийн систем зэрэг дэд бүтцийн ашиглаж буй хөндлөнгийн төлбөр тооцооны механизмын хууль, эрх зүйн үндэслэл нь төлбөр тооцоог эцэслэхтэй холбоотой зохицуулалтыг дэмждэг үү?

Гол асуудал 2. Холбогдох хууль тогтоомжид нийцсэн, тодорхой, ойлгомжтой дүрэм, журам, гэрээний зохицуулалттай байх.

1.2.1 Дүрэм, журам, гэрээгээ тодорхой, ойлгомжтой эсэхийг хэрхэн нотлох вэ?

1.2.2 Дүрэм, журам, гэрээгээ холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хэрхэн нягталдаг вэ? Жишээ нь, эрх зүйн дүн шинжилгээ хийдэг үү. Хууль, эрх зүйн хувьд нийцэхгүй асуудлуудыг олж тогтоон, шийдвэрлэсэн үү? Дүрэм, журам, гэрээгээ хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар хянуулж, үнэлүүлдэг үү?

1.2.3 Дүрэм журам, гэрээгээ хүчин төгөлдөр болгохын өмнө батлуулах шаардлагатай юу? Тийм бол ямар албан тушаалтан хэрхэн баталдаг вэ?

Гол асуудал 3. Холбогдох эрх бүхий байгууллагууд, оролцогчид, шаардлагатай бол тэдний харилцагчдад үйл ажиллагааныхаа эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг тодорхой, ойлгомжтой хэлбэрээр хүргэх боломжтой байх.

1.3.1 Холбогдох эрх бүхий байгууллагууд, оролцогчид, шаардлагатай гэж үзвэл тэдний харилцагчдад үйл ажиллагааныхаа эрх зүйн зохицуулалтын талаар хэрхэн мэдээлдэг вэ?

Гол асуудал 4. Дэд бүтэц нь хэрэгжүүлж болохуйц дүрэм, журам, гэрээтэй байх. Тэдгээр дүрэм, журмын дагуу авч буй арга хэмжээг зогсоох, хүчингүй болгох, хязгаарлах зэрэг асуудал үүсэхгүй байх талаар маш тодорхой зохицуулах.

Дүрэм, журам, гэрээний хэрэгжих боломж

1.4.1 Үйл ажиллагааныхаа дүрэм, журам, гэрээг Гол асуудал 1-д дурдсаны дагуу хэрэгжих бүрэн боломжтой гэсэн дүгнэлтэд хэрхэн хүрсэн бэ? Жишээ нь, эрх зүйн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр үү.

Дүрэм, журмын тодорхой байдал

1.4.2 Дүрэм, журам, гэрээнийхээ хүрээнд авч буй арга хэмжээг зогсоох, хүчингүй болгох, хязгаарлах зэрэг асуудал үүсэхгүй гэсэн дүгнэлтэд хэрхэн хүрсэн бэ? Тэдгээр дүрэм, журам, гэрээнийхээ хүрээнд авч буй арга хэмжээг зогсоох, хүчингүй болгоход хүргэх нөхцөл байдал үүсэх боломжтой юу? Тийм бол ямар нөхцөл байдал вэ?

1.4.3 Дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэгдэх боломжгүй шүүхийн түвшинд очсон асуудал байна уу?

Гол асуудал 5: Хэд хэдэн улсад үйл ажиллагаа явуулдаг дэд бүтцийн хувьд хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас үүсэж болзошгүй эрсдэлүүдийг олж тогтоон, бууруулах.

1.5.1 Хэд хэдэн улсад үйл ажиллагаа явуулдаг бол хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас үүсэж болзошгүй асуудлуудыг хэрхэн олж тогтоон, дүн шинжилгээ хийдэг вэ? Тухайн улс орны хууль тогтоомжтой холбоотой тодорхойгүй зүйлс гарсан үед үүсэж болзошгүй асуудлуудад бие даасан эрх зүйн дүн шинжилгээ хийдэг үү? Ийм ямар асуудлуудад дүн шинжилгээ хийж, хэрхэн шийдвэрлээд байна вэ?

Зарчим 2. Удирдлага зохион байгуулалт

Дэд бүтэц нь үйл ажиллагааныхаа найдвартай, үр ашигтай байдлыг хангаж, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжсэн, олон нийтийн эрх ашиг, холбогдох этгээдийн зорилго, зорилтод нийцсэн тодорхой, ил тод удирдлага зохион байгуулалттай байна.

Гол асуудал 1. Үйл ажиллагааны найдвартай, үр ашигтай байдлыг нэн тэргүүнд тавьж, санхүүгийн тогтвортой байдал, олон нийтийн эрх ашгийг ил тодоор дэмжсэн зорилтууд дэвшүүлэх.

2.1.1 Ямар зорилтууд дэвшүүлээд байна вэ? Тэдгээр зорилтоо сайтар тодорхойлсон уу? Зорилтдоо хүрч буй эсэхийг үйл ажиллагааныхаа гүйцэтгэлээр хэрхэн үнэлдэг вэ?

2.1.2 Тэдгээр зорилтоороо үйл ажиллагааны найдвартай, үр ашигтай байдлыг хэр чухалчилсан бэ? Дэд бүтцийн зорилтууд нь санхүүгийн тогтвортой байдал, олон нийтийн эрх ашгийг ил тодоор хэрхэн дэмжсэн бэ?

Гол асуудал 2. Үүрэг, хариуцлагын зааг ялгааг нарийвчлан тодорхойлсон удирдлага зохион байгуулалттай байх. Энэхүү удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо нь өмчийн эзэд, холбогдох эрх бүхий байгууллагууд, оролцогчид, цаашилбал олон нийтэд нээлттэй, ил тод байх.

Удирдлага, зохион байгуулалт

2.2.1 Захирлуудын зөвлөл (эсвэл түүнтэй адилтгах) болон гүйцэтгэх удирдлагууд нь ямар удирдлага, зохион байгуулалттай ажилладаг вэ? Үүрэг, хариуцлагын зааг ялгааг хэрхэн тодорхойлсон бэ? Удирдлага зохион байгуулалтын талаар ямар баримт бичигт, хэрхэн тусгасан бэ?

2.2.2 Төв банкны хариуцан ажиллуулдаг системийн хувьд аливаа сонирхлын зөрчлийг удирдлага, зохион байгуулалтын түвшинд хэрхэн шийдвэрлэдэг вэ? Үйл ажиллагааны болон хяналтын нэгжүүдийг удирдлага, зохион байгуулалтын хувьд хэр зэрэг зааглаж өгсөн бэ?

2.2.3 Өмчийн эзэд, оролцогчид болон бусад холбогдох этгээдэд хэрхэн хариуцлага хүлээлгэдэг вэ?

Удирдлага, зохион байгуулалтын ил тод байдал

2.2.4 Удирдлага зохион байгуулалтын талаар өмчийн эзэд, холбогдох эрх бүхий байгууллага, оролцогч, олон нийтэд хэрхэн мэдээлдэг вэ?

Гол асуудал 3. Захирлуудын зөвлөл (эсхүл түүнтэй адилтгах)-ийн үүрэг, оролцоог сайтар тодорхойлох нь зүйтэй бөгөөд үйл ажиллагааных нь хэлбэр, гишүүдийнх нь ашиг сонирхлын асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон зохицуулалттай байх. Зөвлөл нь өөрийн болон гишүүдийнхээ ажлын гүйцэтгэлийг тогтмол хянаж, дүгнэх.

Зөвлөлийн үүрэг оролцоо

2.3.1 Захирлуудын зөвлөл ямар үүрэг оролцоотой вэ? Үүрэг оролцоог нь тодорхой зааж өгсөн үү?

2.3.2 Зөвлөл нь ямар хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг, гишүүдийнхээ ашиг сонирхлын асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ? Эдгээртэй холбогдсон асуудлуудыг ямар баримт бичгүүдэд тусгаж, ямар албан тушаалтнууд хандах боломжтойгоор зохицуулсан бэ?

2.3.3 Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой байгуулагдсан дэд хороодын талаар тодорхойлон бичнэ үү. Тэдгээр хороод ямар үүрэг, оролцоо, бүтэц бүрэлдэхүүнтэй вэ?

Гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх

2.3.4 Зөвлөл болон зөвлөлийн гишүүн нэг бүрийн ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, дүгнэдэг вэ?

Гол асуудал 4. Зөвлөл нь хүлээсэн үүргээ гүйцэтгэхийн тулд зохих ур чадварыг эзэмшсэн гишүүдийг ажиллуулж, урамшууллын механизмыг нэвтрүүлэх. Ерөнхийдөө зөвлөлд тухайн ажилд мэргэшсэн гүйцэтгэх удирдлагын түвшний бус албан тушаалтнуудаас оруулах.

2.4.1 Зөвлөлд хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зохих ур чадвар, урамшууллын механизм хэр зэрэг бүрдсэн бэ? Ийм нөхцөлийг хэрхэн бүрдүүлдэг вэ?

2.4.2 Зөвлөлд зохих ур чадвартай гишүүдийг оруулж, тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд тэдэнд ямар урамшуулал өгдөг вэ? Тэдгээр урамшууллыг өгөхдөө тавьж буй зорилтуудынхаа урт хугацааны үр дүнг хэрхэн хардаг вэ?

2.4.3 Зөвлөлд удирдах албан тушаал хашдаггүй эсхүл хараат бус гишүүд байгаа юу? Хэрэв тийм бол хэдэн хараат бус гишүүн байна вэ?

2.4.4 Хэрвээ зөвлөлд хараат бус гишүүд байгаа бол тэдгээр хараат бус гишүүдээ хэрхэн сонгодог вэ? Хараат бус гэх тэдгээр гишүүд олон нийтийн өмнө ил тод байдаг уу?

Гол асуудал 5. Удирдлагын түвшний албан тушаалтны үүрэг, хариуцлагыг сайтар тодорхойлж өгөх. Удирдах албан тушаалтан нь дэд бүтцийн үйл ажиллагааг хөтлөн явуулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүлээсэн үүргээ гүйцэтгэх ёс суртахуун, ур чадвар, зохих дадлага туршлагатай байх.

Удирдах албан тушаалтны үүрэг, оролцоо

2.5.1 Удирдлагын түвшний албан тушаалтан нь ямар үүрэг хүлээдэг вэ? Тэдгээрийг нь сайтар тодорхойлж өгсөн уу?

2.5.2 Удирдлагын түвшний албан тушаалтны үүрэг, оролцоог хэрхэн тодорхойлж, үнэлдэг вэ?

Дадлага туршлага, ур чадвар, ёс суртахуун

2.5.3 Удирдлагын түвшний албан тушаалтан нь дэд бүтцийн үйл ажиллагааг хөтлөх явуулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зохих дадлага туршлага, ур чадварыг хэр зэрэг эзэмшсэн, ёс суртахууны хувьд хэр тохиромжтой вэ?

2.5.4 Удирдлагын түвшний албан тушаалтныг ажлаас чөлөөлөхтэй холбогдсон ямар зохицуулалт байна вэ?

Гол асуудал 6. Зөвлөл нь дэд бүтцийн эрсдэл удирдлагын бодлого бүхий эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлон баталж, холбогдох шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхойлж, хямрал болон онцгой байдлын үед гаргах шийдвэрт анхаарал хандуулах. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын нэгжүүдийн эрх мэдэл, нөөц бололцоо, хараат бус байдал, зөвлөлд шууд хандах бололцоог бүрэн хангаж өгөх.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

2.6.1 Зөвлөлөөс тодорхойлж баталсан эрсдэлийн удирдлагын ямар тогтолцоог хэрэгжүүлж байна вэ? Ямар тушаал, шийдвэрээр гаргасан бэ?

2.6.2 Энэ тогтолцоо нь дэд бүтцийн эрсдэл даван туулах бодлогыг хэрхэн тодорхойлж, холбогдох шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг, хариуцлагыг хэрхэн тогтоож, хямралын болон онцгой байдлын үед шийдвэр гаргахад хэрхэн анхаарал хандуулсан бэ?

2.6.3 Эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрхэн тодорхойлж, баталж, үнэлдэг вэ?

Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын нэгжүүдийн эрх мэдэл, хараат бус байдал

2.6.4 Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын нэгжүүд нь ямар үүрэг, оролцоо, эрх мэдэл, нөөц бололцоотой болох мөн үйл ажиллагаагаа хэнд, хэрхэн тайлагнадаг вэ?

2.6.5 Эрсдэлийн удирдлагын загварчлал нэвтрүүлэх, ашиглах тал дээр зөвлөл хэрхэн анхаардаг вэ? Тэдгээр загвар, аргачлалыг албан ёсоор ашиглах эсэх шийдвэрийг хэрхэн гаргадаг вэ?

Гол асуудал 7. Зөвлөл нь шууд ба шууд бус оролцогч, холбогдох этгээдийн хууль ёсны эрх ашгийг дэд бүтцийн загвар хэлбэр, бодлого, стратеги, дүрэм, журам, томоохон шийдвэрүүдэд зохих ёсоор тусгах бололцоог хангаж ажиллах. Томоохон шийдвэрүүдийг холбогдох этгээдэд мэдэгдэх шаардлагатай ба энэ нь нийт зах зээлд шууд нөлөөлөхөөр бол олон нийтэд холбогдох мэдээллийг хүргэх.

Холбогдох этгээдийн эрх ашгийг тодорхойлж, авч хэлэлцэх

2.7.1 Дэд бүтцийн загвар хэлбэр, бодлого, стратеги, дүрэм, журам зэрэгтэй холбоотой шийдвэр гаргахдаа оролцогчид болон холбогдох этгээдийн эрх ашгийг хэрхэн авч үздэг вэ?

2.7.2 Зөвлөлөөс шийдвэр гаргахдаа шууд ба шууд бус оролцогчид, холбогдох этгээдийн санал бодлыг хэрхэн авч үздэг вэ? Жишээ нь, оролцогчдыг эрсдэлийн удирдлагын хороо болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хороодод оруулсан уу? Холбогдох этгээд болон дэд бүтцийн хоорондох ашиг сонирхлын зөрчлийг хэрхэн авч хэлэлцдэг вэ?

Ил тод байдал

2.7.3 Зөвлөлөөс гаргасан томоохон шийдвэр нь холбогдох этгээд шаардлагатай тохиолдолд олон нийтэд хэр зэрэг хүрдэг вэ?

Зарчим 3. Эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоо

Дэд бүтэц нь хууль эрх зүйн, зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, үйл ажиллагааны болон холбогдох бусад эрсдэлийг цогцоор нь удирдах эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоотой байна.

Гол асуудал 1. Өөрийн болон бусдын үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлүүдийг олж тогтоох, үнэлэх, хянах, удирдах эрсдэлийн удирдлагын бодлого, журам, системтэй байх ба эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо тогтмол үнэлгээ хийх.

Өөрийн болон бусдын үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлүүд

3.1.1 Өөрийн болон бусдын үйл ажиллагаанаас үүдэлтэй ямар эрсдэлүүд байна вэ?

Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, систем

3.1.2 Өөрийн болон бусдын үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлж, хянаж, удирдах ямар бодлого, журам, хяналтын механизм байна вэ?

3.1.3 Тэдгээр эрсдэлүүдийг олж тогтоон, үнэлж, хянаж, удирдах эрсдэлийн удирдлагын ямар систем байна вэ?

3.1.4 Энэхүү эрсдэлийн удирдлагын систем нь нийт дэд бүтцийн хэмжээнд, цаашилбал оролцогчид болон тэдгээрийн харилцагчид зэрэг холбогдох бусад талуудын түвшинд үүсээд буй хүндрэлийг шийдвэрлэх бололцоог хэрхэн хангасан бэ?

Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, системийн үнэлгээ

3.1.5 Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, системийг хэрхэн боловсруулж, сайшаан баталдаг вэ?

3.1.6 Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, системийг хэрхэн үнэлдэг вэ?

3.1.7 Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, системийг хэр тогтмол үнэлж, шинэчлэн сайжруулдаг вэ? Үнэлгээгээр эрсдэлийн түвшин, зах зээлийн болон орчны нөхцөл байдалд хэрхэн анхаарал хандуулдаг вэ?

Гол асуудал 2: Оролцогчдоос болон тэдгээрийн харилцагчдаас системд учруулж буй эрсдэлийг удирдаж, хянахын тулд тэдэнд дэмжлэг үзүүлж байх.

3.2.1 Системд учруулж буй эрсдэлээ хянаж, удирдахад нь зориулж оролцогчид болон тэдгээрийн харилцагчдыг ямар мэдээллээр хангадаг вэ?

3.2.2 Системд учруулж буй эрсдэлээ хянаж, удирдахад нь зориулж оролцогчид болон тэдгээрийн харилцагчдад ямар дэмжлэг үзүүлдэг вэ?

3.2.3 Оролцогчид болон тэдгээрийн харилцагчдад системд учруулж буй эрсдэлээ хянаж, удирдах бололцоог олгохын тулд бодлого, журам, системээ хэрхэн тодорхойлсон вэ?

Гол асуудал 3: Бусад этгээд (бусад дэд бүтэц, төлбөр тооцооны банкууд, эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагууд (liquidity providers), мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгчид (service providers) зэрэг)-тэй тогтоосон бизнесийн харилцаа холбооноос үүдэлтэй томоохон эрсдэлүүдийг тогтмол үнэлж, удирдах эрсдэлийн удирдлагын оновчтой арга хэрэгслийг бий болгох.

Томоохон эрсдэлүүд

3.3.1 Бусад этгээдтэй тогтоосон бизнесийн харилцаа холбооноос үүдэлтэй томоохон эрсдэлүүдийг хэрхэн олж тогтоодог вэ? Одоогоор олж тогтоогоод буй ямар томоохон эрсдэлүүд байна вэ?

3.3.2 Тэдгээр эрсдэлүүдийг хэрхэн, хэр тогтмол үнэлж, хяналт тавьдаг вэ?

Эрсдэлийн удирдлагын арга хэрэгслүүд

3.3.3 Бусад этгээдтэй тогтоосон бизнесийн харилцаа холбооноос үүдэлтэй эрсдэлүүдийг удирдах эрсдэлийн удирдлагын ямар арга хэрэгсэл ашигладаг вэ?

3.3.4 Эрсдэлийн удирдлагын тэдгээр арга хэрэгслийнхээ үр өгөөжийг хэрхэн үнэлдэг вэ? Тэдгээр эрсдэлийг удирдахад ашиглаж буй эрсдэлийн удирдлагын арга хэрэгслүүдийг хэрхэн үнэлж дүгнэдэг вэ? Ийм үнэлэлт дүгнэлтийг хэр тогтмол хийдэг вэ?

Гол асуудал 4: Нэн чухал үйлчилгээг тасралтгүй үзүүлэх боломжгүй түвшинд хүрч болохуйц нөхцөл байдлыг тодорхойлж, гарсан саатлыг засварлах, системийн ачааллыг шат дараалалтайгаар багасгах боломжуудын үр дүнг үнэлэх. Үнэлгээний үр дүнд үндэслэн саатлыг засварлах, ачааллыг шат дараалалтайгаар багасгах оновчтой төлөвлөгөөг боловсруулах. Түүнчлэн, шаардлагатай гэж үзвэл тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй мэдээллээр холбогдох эрх бүхий байгууллагыг хангах нь зүйтэй.

Нэн чухал үйлчилгээг үзүүлэх боломжгүй түвшинд хүргэж болохуйц нөхцөл байдал

3.4.1 Нэн чухал үйлчилгээг үзүүлэх боломжгүй түвшинд хүргэж болохуйц нөхцөл байдлыг хэрхэн тодорхойлдог вэ? Одоогоор ямар нөхцөл байдлын улмаас ийм түвшинд хүрч болзошгүй байна вэ?

3.4.2 Тухайн нөхцөл байдлыг тодорхойлохдоо хараат бус байдал болон холбогдох эрсдэлүүдийг хэрхэн авч үзсэн бэ?

Саатлыг засварлах, ачааллыг шат дараалалтай бууруулах

3.4.3 Саатлыг засварлах, ачааллыг шат дараалалтай бууруулах ямар төлөвлөгөө байна вэ?

3.4.4 Саатлыг засварлах, ачааллыг шат дараалалтай багасгах стратеги төлөвлөгөөнийхөө хүрээнд нэн чухал үйлчилгээг тасралтгүй үзүүлэх боломжийг хэрхэн бүрдүүлсэн вэ?

3.4.5 Саатлыг засварлах, ачааллыг шат дараалалтай багасгах төлөвлөгөөгөө хэрхэн үнэлж, шинэчлэн сайжруулдаг вэ? Ийм үнэлгээ, шинэчлэлт сайжруулалтыг хэр тогтмол хийдэг вэ?

Зарчим 4. Зээлийн эрсдэл

Дэд бүтэц нь оролцогчдодоо олгосон зээлийн хүндрэл болон төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанаас бий болж болзошгүй зээлийн эрсдэлийг бодитоор үнэлж, хянаж, удирдах шаардлагатай. Дэд бүтэц нь оролцогч бүрт олгосон зээлийн хүндрэлээс найдвартай хамгаалах санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байх шаардлагатай.

Түүнчлэн, илүү эрсдэл бүхий үйл ажиллагаатай эсхүл олон улс оронд системийн талаас нэн чухал үүрэг гүйцэтгэдэг АКТ-ийн хувьд болзошгүй нөхцөл байдлаас гарах санхүүгийн хангалттай нэмэлт эх үүсвэртэй байх шаардлагатай. Тухайлбал, зах зээлийн онцгой нөхцөл байдлын улмаас АКТ-д хамгийн том зээлийн эрсдэл учруулж болохуйц хоёр томоохон оролцогч болон тэдний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох нөхцөл үүсэж болох юм. Бусад бүх АКТ-ийн хувьд зах зээлийн онцгой нөхцөл байдлын улмаас хамгийн том зээлийн эрсдэл учруулж болохуйц томоохон оролцогч болон түүний охин компаниуд нь үүргээ биелүүлээгүйгээс үүсэх эрсдэлийг даван туулах хангалттай санхүүгийн эх үүсвэртэй байх шаардлагатай.

Гол асуудал 1. Оролцогчдод олгосон зээлийн хүндрэл болон төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанаас бий болж болзошгүй зээлийн эрсдэлийг удирдах найдвартай тогтолцоотой байх. Зээлийн эрсдэл нь олгосон эрсдэлийн тухайн үеийн болон ирээдүйд үүсэж болзошгүй хүндрэлээс үүдэлтэй байж болох юм.

4.1.1 Оролцогчдод олгосон зээлийн хүндрэл болон төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанаас бий болж болзошгүй зээлийн эрсдэлийг удирдах ямар тогтолцоотой вэ?

4.1.2 Зах зээлийн нөхцөл байдал, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэгтэй холбоотой асуудлуудыг тусгах зорилгоор энэхүү тогтолцоогоо хэр тогтмол үнэлж дүгнэдэг вэ?

Гол асуудал 2. Зээлийн эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлж, олгосон зээлийн хүндрэлийг тогтмол үнэлж, хяналт тавих эрсдэлийн удирдлагын оновчтой арга хэрэгсэл ашиглах.

4.2.1 Зээлийн эрсдэл үүсгэж буй хүчин зүйлсийг хэрхэн олж тогтоодог вэ? Одоогоор ямар хүчин зүйлсийг олж тогтоогоод байна вэ?

4.2.2 Зээлийн хүндрэлийг хэрхэн үнэлж, хянадаг вэ? Зээлийн хүндрэлийг хэр тогтмол үнэлдэг, шаардлагатай бол хэр тогтмол үнэлэх боломжтой вэ? Мэдээлэл хэр цагаа олсон байж чаддаг вэ?

4.2.3 Зээлийн эрсдэл үүсгэж буй тогтоогдсон хүчин зүйлсэд хяналт тавих ямар арга хэрэгслүүд байна вэ? Жишээ нь, RTGS системээр эсхүл төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) зарчмаар төлбөр тооцоо хийх, өдрийн зээлийн хэмжээ болон дебит гүйлгээний дүнд хязгаарлалт тогтоох, зээлийн төвлөрлийн хязгаар тогтоох, позицийг өдөр тутам зах зээлийн үнээр нь үнэлэх гэх мэт. Эдгээр арга хэрэгслийн үр дүнг хэрхэн үнэлдэг вэ?

Гол асуудал 3. Төлбөрийн систем болон ҮЦТТС-ийн хувьд: Барьцаа хөрөнгө, түүнтэй адилтгах санхүүгийн бусад эх үүсвэр ашиглан оролцогч бүрт олгосон зээлийн одоогийн болон ирээдүйн болзошгүй хүндрэлээс хамгаалах (Барьцаа хөрөнгийн тухай Зарчим 5-ыг харна уу). Оролцогчид нь төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаатай холбоотойгоор зээлийн хүндрэлд орох эрсдэлтэй, тогтоосон хугацаанд үр дүнгийн тооцоо хийдэг төлбөр тооцооны систем (DNS) болон ҮЦТТС-ийн хувьд: тухайн дэд бүтэц нь системд зээлийн хамгийн том хүндрэл үүсгэж болохуйц томоохон хоёр оролцогч, тэдний охин компаниудад учирсан зээлийн хүндрэлийг шийдвэрлэх хангалттай эх үүсвэртэй байх.

Оролцогч бүрийн зээлийн хүндрэлийг шийдвэрлэх

4.3.1 Оролцогч бүрийн зээлийн одоогийн болон ирээдүйн болзошгүй хүндрэлийг хэрхэн шийдвэрлэдэг вэ? Тэдгээр хүндрэлийг шийдвэрлэхэд ашигладаг санхүүгийн эх үүсвэрээ ямар хөрөнгөөр бүрдүүлсэн бэ? Тухайн эх үүсвэрийг дайчлах боломж хэр хангагдсан бэ?

4.3.2 Тухайн санхүүгийн эх үүсвэрээр систем дэх одоогийн болон ирээдүйн болзошгүй хүндрэлийг хэр зэрэг найдвартай шийдвэрлэх боломжтой вэ? Эх үүсвэрийн хүрэлцээтэй эсэхийг хэр тогтмол үнэлдэг вэ?

Тогтоосон хугацаанд үр дүнгийн тооцоо хийдэг төлбөр тооцооны систем болон ҮЦТТС

4.3.3 Тогтоосон хугацаанд үр дүнгийн тооцоо хийдэг төлбөр тооцооны систем болон үнэт цаасны төлбөр тооцооны системийн хувьд оролцогчид төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанаас үүдэлтэй зээлийн хүндрэлд ордог уу? Системд зээлийн хүндрэл үүссэн тохиолдолд систем тэдгээр хүндрэлийг хэрхэн хянаж, үнэлдэг вэ?

4.3.4 Тогтоосон хугацаанд үр дүнгийн тооцоо хийдэг төлбөр тооцооны систем болон үнэт цаасны төлбөр тооцооны системийн хувьд оролцогчдын дунд зээлийн хүндрэл үүсэх боломжтой бол системд хамгийн том зээлийн хүндрэл үүсгэж болохуйц томоохон хоёр

оролцогч, тэдний охин компаниуд үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх нөхцөл байдлыг санхүүгийн эх үүсвэрээрээ хэр зэрэг шийдвэрлэх боломжтой вэ?

Гол асуудал 4. АКТ нь маржин болон урьдчилан байршуулсан санхүүгийн бусад эх үүсвэрийг ашиглан оролцогч бүрийг үүссэн болон үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах (Барьцаа хөрөнгийн тухай Зарчим 5, маржины тухай Зарчим 6-г харна уу). Түүнчлэн, илүү эрсдэл бүхий үйл ажиллагаа явуулдаг, хэд хэдэн улс оронд системийн хувьд нэн чухлаар тооцогдох АКТ-ийн хувьд болзошгүй нөхцөл байдлаас хамгаалах хангалттай хэмжээний санхүүгийн нэмэлт эх үүсвэртэй байх. Тухайлбал, зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед АКТ-д зээлийн хамгийн том эрсдэл учруулж болохуйц хоёр оролцогч, тэдний салбар компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болж болох юм. Бусад АКТ-ийн хувьд болзошгүй нөхцөл байдлаас хамгаалах хангалттай хэмжээний санхүүгийн нэмэлт эх үүсвэртэй байх. АКТ нь санхүүгийн нийт эх үүсвэрийн хэмжээг тогтоох үндэслэлийг холбогдох баримт бичгээр баталгаажуулах, зохистой байдлаар удирдах.

Оролцогчийг одоо үүсээд буй болон ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах

4.4.1 АКТ нь оролцогч бүрийг одоо үүсээд буй болон ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс хэрхэн хамгаалдаг вэ? АКТ нь одоо үүсээд буй болон ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалахад зарцуулах эх үүсвэрийг ямар хөрөнгөөр бүрдүүлсэн бэ? Тэдгээр санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн удирддаг вэ?

4.4.2 АКТ нь тэдгээр санхүүгийн эх үүсвэрийг ашиглан одоо үүсээд буй болон ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс хэр зэрэг найдвартай хамгаалдаг вэ? АКТ нь эх үүсвэрийнхээ хүрэлцээтэй байдлыг хэр тогтмол үнэлдэг вэ?

Эрсдэлийн түвшин ба системийн хувьд ач холбогдолтой байдал

4.4.3 АКТ нь илүү эрсдэл бүхий үйл ажиллагаа эрхэлдэг үү? АКТ нь хэд хэдэн улс оронд системийн хувьд ач холбогдол бүхий үйл ажиллагаа явуулдаг уу?

Санхүүгийн нэмэлт эх үүсвэр

4.4.4 Зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед АКТ-д зээлийн хамгийн том эрсдэл учруулж болохуйц хоёр оролцогч, тэдний салбар компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох зэрэг болзошгүй нөхцөлд ашиглах санхүүгийн ямар нэмэлт эх үүсвэр байна вэ?

4.4.5 Хэрэв АКТ нь илүү эрсдэл бүхий үйл ажиллагаа эрхэлдэг, хэд хэдэн улс оронд системийн хувьд ач холбогдолтой гэж тооцогддог бол санхүүгийн нэмэлт эх үүсвэрээрээ зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед зээлийн хамгийн том эрсдэл учруулж болохуйц хоёр оролцогч, тэдний салбар компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болж болох эрсдэлээс хэр зэрэг хамгаалдаг вэ?

4.4.6 АКТ нь санхүүгийн нэмэлт эх үүсвэрийнхээ хүрэлцээтэй байдлыг хэр тогтмол үнэлдэг вэ?

Санхүүгийн эх үүсвэрийн өмчлөл, удирдлага

4.4.7 АКТ нь холбогдох баримт бичигт санхүүгийн нийт эх үүсвэрийнхээ өмчлөлийг хэрхэн баталгаажуулдаг вэ?

4.4.8 АКТ нь санхүүгийн нийт эх үүсвэрээ удирдах ямар удирдлага, зохион байгуулалттай вэ?

Гол асуудал 5. АКТ нь мэдрэмтгий байдлын шинжилгээг (stress testing) нарийвчлан хийх замаар зах зээлийн онцгой нөхцөл байдал үүссэн үед нэг ба хэд хэдэн оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд байлгавал зохих санхүүгийн нийт эх үүсвэрийн хэмжээг тодорхойлж, хүрэлцээтэй байдлыг нь тогтмол шалгах. АКТ нь мэдрэмтгий байдлын шинжилгээний үр дүнг шийдвэр гаргах түвшний албан тушаалтанд тайлагнах, санхүүгийн нийт эх үүсвэрийнхээ хүрэлцээтэй байдлыг үнэлж, тогтоохдоо шинжилгээний үр дүнг ашиглах талаар дүрэм, журамтай байх. Мэдрэмтгий байдлын шинжилгээг холбогдох стандарт, урьдчилан тогтоосон параметр, таамаглал ашиглан өдөр тутам хийх. АКТ нь зах зээлийн тухайн үеийн болон цаашдын нөхцөл байдлыг харгалзан тодорхойлоход ашигладаг мэдрэмтгий байдлын шинжилгээ, түүний загварчлал, үндсэн параметр, таамаглалыг иж бүрэн, нарийвчилсан байдлаар хамгийн багадаа сар тутам хийх. АКТ нь зах зээл тогтворгүй, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар суларсан, оролцогчийн байршуулсан позицйн хэмжээ нэлээд өссөн үед мэдрэмтгий байдлын шинжилгээг илүү олон удаа хийх. АКТ нь эрсдэлийн удирдлагын загвараа хамгийн багадаа жил тутам шинэчлэн батлах.

Мэдрэмтгий байдлын шинжилгээ

4.5.1. Зах зээлийн онцгой нөхцөл байдал үүссэн үед нэг ба хэд хэдэн оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд АКТ нь байлгавал зохих санхүүгийн нийт эх үүсвэрийнхээ хүрэлцээтэй байдлыг хэрхэн тодорхойлж, мэдрэмтгий байдлын шинжилгээг хийдэг вэ? АКТ нь санхүүгийн эх үүсвэртээ мэдрэмтгий байдлын шинжилгээг хэр тогтмол хийдэг вэ?

4.5.2 Мэдрэмтгий байдлын шинжилгээний үр дүнг АКТ-ийн шийдвэр гаргах түвшний холбогдох албан тушаалтанд хэрхэн мэдээлдэг вэ? АКТ нь санхүүгийн нийт эх үүсвэрийнхээ хүрэлцээг үнэлж, тодорхойлоход шинжилгээний үр дүнг хэрхэн ашигладаг вэ?

Үнэлгээ, баталгаажуулалт

4.5.3 АКТ нь мэдрэмтгий байдлын шинжилгээний таамаглал болон параметрийн үр дүнтэй, тохиромжтой байдлыг хэр тогтмол үнэлдэг вэ? АКТ нь мэдрэмтгий байдлын шинжилгээгээр позицйн болон үнийн гэнэтийн томоохон хэлбэлзэл, позицйн төвлөрөл, зах зээлийн эрэлт хэрэгцээ, эрсдэлийн хүчин зүйлс зэрэгт хэрхэн анхаарал хандуулдаг вэ?

4.5.4 АКТ нь эрсдэлийн удирдлагын загвараа хэрхэн баталгаажуулдаг вэ? Хэр тогтмол баталгаажуулдаг вэ? Ямар албан тушаалтан үүнийг гүйцэтгэдэг вэ?

Гол асуудал 6. АКТ нь мэдрэмтгий байдлын шинжилгээг хийхдээ болзошгүй нөхцөл байдлын үр дагаврыг авч үзэх ёстой бөгөөд ингэхдээ хүлээсэн үүргээ биелүүлээгүй хоёр оролцогчийн позиц болон өр төлбөрийг барагдуулах үед гарч болзошгүй үнийн өөрчлөлтийг харгалзан үзэх. Болзошгүй нөхцөл байдал гэдэгт үнийн түүхэн дээд

хэлбэлзэл, үнэ тодорхойлогч хүчин зүйлс болон өгөөжийн муруйн өөрчлөлт, тодорхой хугацааны туршид нэгэн зэрэг үүсэх санхүүжилтийн болон хөрөнгийн хүндрэлийг хамааруулах.

4.6.1 АКТ нь мэдрэмтгий байдлын шинжилгээ хийхдээ ямар нөхцөл байдлыг харгалзан үздэг вэ? Тэдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэх ямар дүн шинжилгээ хийдэг вэ? Эдгээр нөхцөл байдалд үнийн түүхэн дээд хэлбэлзэл, үнэ тодорхойлогч хүчин зүйлс болон өгөөжийн муруйн өөрчлөлт, тодорхой хугацааны туршид нэгэн зэрэг үүсэх санхүүжилтийн болон хөрөнгийн хүндрэлийн үеийг хамруулдаг уу?

Гол асуудал 7. Тухайн нэг болон хэсэг бүлэг оролцогч үүргээ биелүүлээгүйн улмаас хүлээж болзошгүй зээлийн алдагдлыг бүрэн шийдвэрлэх тодорхой дүрэм, журамтай байх. Тэдгээр дүрэм, журмын хүрээнд нөхөн төлөгдөх найдваргүй зээлийн алдагдлыг хэрхэн хүлээн зөвшөөрөх, эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагуудаас зээлэх боломжтой зээлийн эргэн төлөлтийн асуудлуудыг зохицуулах. Түүнчлэн, үйл ажиллагааныхаа найдвартай, тогтвортой байдлыг хангах зорилгоор онцгой тохиолдолд дайчлах санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх арга хэлбэрүүдийг тэдгээр дүрэм, журмаар тодорхойлох.

Зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх

4.7.1 Тухайн нэг болон хэсэг бүлэг оролцогч үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэж болзошгүй зээлийн алдагдлыг дүрэм, журмын хүрээнд хэрхэн зохицуулсан бэ? Тэдгээр дүрэм, журамдаа нөхөн төлөгдөх найдваргүй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх, эх үүсвэр зээлдүүлэгч байгууллагуудаас зээлэх боломжтой зээлийн эргэн төлөлтийн асуудлуудыг хэрхэн зохицуулсан вэ?

Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх

4.7.2 Онцгой тохиолдолд дайчлах санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх талаар ямар дүрэм, журамтай вэ?

ЗАРЧИМ 5. Барьцаа хөрөнгө

Дэд бүтэц нь өөрийн болон оролцогчдынхоо зээлийн хүндрэлийг удирдах зорилгоор барьцаа хөрөнгө байршуулахыг шаарддаг ба зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, зах зээлийн эрсдэл багатай барьцаа хөрөнгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Түүнчлэн, дэд бүтэц нь барьцаа хөрөнгийн үнэлгээний хорогдуулалтын тогтвортой хувь (haircuts) болон хөрөнгө төвлөрлийн хязгаар тогтоож, мөрдөх шаардлагатай.

Гол асуудал 1. Зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, зах зээлийн эрсдэл багатай, холбогдох шалгуурын дагуу барьцаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч болох хөрөнгийг тодорхойлж өгөх.

5.1.1. Тухайн хөрөнгийг барьцаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх эсэхийг хэрхэн тодорхойлдог вэ? Тусгай нөхцөлтэйгээр хүлээн зөвшөөрөх бол тэдгээр нөхцөлийг хэрхэн тодорхойлдог вэ? Барьцаа хөрөнгийн шалгуураа хэр тогтмол шинэчилдэг вэ? Тусгай нөхцөлтэй барьцаа хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тохиолдол хэр их гардаг, түүнтэй холбогдуулан тавьж буй хязгаарлалт бий юу?

5.1.2. Барьцаа хөрөнгөд тавигдах шалгуурыг хангуулах зорилгоор тухайн хөрөнгөд хэрхэн хяналт тавьдаг вэ?

5.1.3. Зээлийн чанар муудсанаас үүсэх эрсдэлийг хэрхэн олж тогтоон, бууруулдаг вэ? Жишээ нь, хүлээн зөвшөөрөх барьцаа хөрөнгүүдийг тодорхойлох, барьцаа хөрөнгийн төвлөрөлд хязгаар тогтоох.

Гол асуудал 2. Нарийвчилсан үнэлгээний практик туршлага нэвтрүүлж, зах зээлийн мэдрэмтгий нөхцөл байдлыг харгалзан тооцсон үнэлгээний хорогдуулалтын хувь тогтоох.

Үнэлгээний практик туршлага

5.2.1 Барьцаа хөрөнгийг зах зээлийн үнээр нь хэр тогтмол үнэлдэг вэ? Хамгийн наад зах нь өдөр тутам үнэлж чаддаг уу?

5.2.2 Хөрөнгийн зах зээлийн үнэ бодит үнэ цэнийг нь илэрхийлэх боломжгүй үед үнэлгээ хийх эрх хэр зэрэг олгогдсон бэ?

Үнэлгээний хорогдуулалтын хувь

5.2.3 Үнэлгээний хорогдуулалтын хувийг хэрхэн тогтоодог вэ?

5.2.4 Зах зээл мэдрэмтгий үед тухайн барьцаа хөрөнгийн үнэ цэнэ ихээхэн унах зэрэг тохиолдолд үнэлгээний хорогдуулалтын хувийг хангалттай тогтоосон эсэхээ хэрхэн шалгаж, баталгаажуулдаг вэ? Ийм шалгалтыг хэр тогтмол хийдэг вэ?

Гол асуудал 3: Эдийн засгийн төлөв байдлаас шалтгаалан байнга өөрчлөх шаардлага төдийлөн гарахааргүй зах зээлийн мэдрэмтгий нөхцөлд ч тохирох үнэлгээний хорогдуулалтын тогтвортой хувь тогтоох.

5.3.1. Үнэлгээний хорогдуулалтын хувийг тогтоохдоо эдийн засгийн төлөв байдлыг хэрхэн тодорхойлж, үнэлдэг вэ? Эдийн засгийн төлөв байдлаас шалтгаалан байнга өөрчлөх шаардлагыг багасгах тал дээр хэрхэн анхаарч байна вэ? Жишээ нь, үнэлгээний хорогдуулалтын хувь тогтоохдоо зах зээлийн мэдрэмтгий нөхцөл байдлыг авч үзэх.

Гол асуудал 4. Дэд бүтэц нь хөрөнгийг үнэ цэнийн мэдэгдэхүйц хорогдолгүйгээр түргэн хөрвүүлэх боломжтой байхын тулд тухайн төрлийн хөрөнгийг хэт төвлөрүүлэхээс зайлсхийх.

5.4.1 Төлбөр барагдуулахад үүсэж болзошгүй алдагдлыг хязгаарлах үүднээс тодорхой төрлийн хөрөнгийн төвлөрөл үүсэхээс зайлсхийх талаар ямар бодлого баримталж байна вэ? Ийм бодлогыг тодорхойлохдоо ямар хүчин зүйлсийг авч үздэг вэ?

5.4.2 Тухайн төрлийн барьцаа хөрөнгийг хүлээн зөвшөөрөх хэмжээг тодорхойлох хөрөнгө төвлөрлийн бодлого, практик туршлагаа хэрхэн үнэлж, дүгнэдэг вэ? Ийм үнэлэлт, дүгнэлтийг хэр тогтмол хийдэг вэ?

Гол асуудал 5. Хилийн чанад дахь хөрөнгийг барьцаанд хүлээн зөвшөөрдөг бол тухайн хөрөнгийг ашиглахтай холбоотой эрсдэлийг бууруулж, цаг алдалгүй ашиглах боломжтой эсэхийг нягтлан шалгах.

5.5.1 Хилийн чанад дахь хөрөнгийг барьцаанд хүлээн зөвшөөрснөөс учирч болзошгүй хууль эрх зүйн, үйл ажиллагааны, зах зээлийн ямар эрсдэлүүд байна вэ ?

5.5.2. Хилийн чанад дахь барьцаа хөрөнгийг цаг алдалгүй ашиглах боломжтой эсэхийг хэрхэн нягтлан шалгадаг вэ?

Гол асуудал 6. Сайтар төлөвлөгдсөн, үйл ажиллагааны хувьд уян хатан барьцаа хөрөнгийн удирдлагын систем ашиглах.

Барьцаа хөрөнгийн удирдлагын системийн загвар дизайн

5.6.1 Барьцаа хөрөнгийн удирдлагын системийн үндсэн үйл ажиллагааны талаар тайлбарлана уу?

5.6.2 Байршуулсан барьцаа хөрөнгийн дахин ашиглалт, түүнтэй холбогдсон эрхийн асуудалд хэрхэн, хэр тогтмол хяналт тавьдаг вэ?

Үйл ажиллагааны уян хатан байдал

5.6.3 Барьцаа хөрөнгийн удирдлагын системд байнгын хяналт болон хөрөнгийн удирдлагатай холбогдсон өөрчлөлтүүдийг хэрхэн, хэр тогтмол хийдэг вэ?

5.6.4 Зах зээлийн мэдрэмтгий нөхцөлд ч үйл ажиллагааныхаа тогтвортой байдлыг хангахын тулд барьцаа хөрөнгийн удирдлагын системийг боловсон хүчнээр хэр зэрэг хангасан бэ?

Зарчим 6. Маржин

АКТ нь эрсдэлд суурилсан, хяналт, үнэлгээнд тогтмол хамрагддаг, үр дүнтэй маржины систем ашиглан оролцогчдод олгосон зээлийн эрсдэлийг удирдана.

Гол асуудал 1. АКТ нь тухайн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын багц, зах зээлийн онцлог болон холбогдох эрсдэлтэй уялдуулан маржины түвшин тогтоох системтэй байх.

Маржин тооцох аргачлал

6.1.1 АКТ нь ямар бүтэц хэлбэртэй маржины систем ашигладаг вэ? Ялангуяа одоогийн болон ирээдүйн болзошгүй эрсдэлийг удирдах ямар функцтэй вэ? Хэрэв АКТ нь маржин систем ашигладаггүй бол эрсдэлээ бууруулахын тулд эрсдэлийн удирдлагын ямар арга хэрэгсэл ашигладаг вэ? Тэдгээр арга хэрэгслийг ашиглах нь маржины систем ашигласантай хэр зэрэг ойролцоо үр дүн өгдөг вэ?

6.1.2 Маржин тооцох аргачлалын талаар холбогдох баримт бичигт тусгасан уу?

6.1.3 Оролцогчийг эрсдэлийн удирдлагаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үүднээс АКТ нь маржин тооцох аргачлалын талаар хэр нарийвчилсан мэдээллээр хангадаг вэ?

Зээлийн эрсдэл

6.1.4 АКТ нь тухайн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын багц, зах зээлийн онцлогтой нийцүүлэн зээлийн эрсдэлээ ямар хүчин зүйлсээр тодорхойлдог вэ?

6.1.5 АКТ нь маржины шаардлагаа тухайн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын багц, зах зээлийн онцлог болон эрсдэлтэй хэр нийцүүлэн тогтоодог вэ?

Үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг

6.1.6 Оролцогч төлбөр хийх боломжгүй болж позиц нь маржины дутагдалд орох эрсдэлийг АКТ нь хэрхэн шийдвэрлэдэг бэ?

6.1.7 АКТ нь маржин цуглуулах болон төлбөр гүйцэтгэх хуваариа хэрхэн хэрэгжүүлдэг вэ? Хэрэв АКТ нь цагийн зөрүүтэй бүс нутагт оролцогчтой бол тухайн бүс нутгийн зах зээл, төлбөр тооцооны системийн ажиллах цагийн хуваарь зэргээс үүдэлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг бэ?

Гол асуудал 2. АКТ нь маржины систем дэх ханшийн мэдээллийг цаг тухайд нь шинэчлэх найдвартай эх сурвалжтай байх. Түүнчлэн, ханшийн мэдээлэл бэлэн болоогүй эсвэл найдвартай биш гэж үзсэн нөхцөлд АКТ нь холбогдох асуудлыг зохицуулах журам, нарийвчилсан үнэлгээний загвартай байх.

Ханшийн мэдээллийн эх үүсвэр

6.2.1 АКТ нь маржин тооцох загварчлалдаа ямар эх үүсвэрээс ханшийн мэдээллийг авч ашигладаг вэ? АКТ нь ямар мэдээлэл ашиглан анхны маржинг тогтоодог вэ?

6.2.2 АКТ нь маржины системдээ оруулж буй ханшийн мэдээллийг цагаа олсон, найдвартай болохыг хэрхэн тодорхойлдог вэ?

Ханшийн тооцоолол

6.2.3 Ханшийн мэдээлэл бэлэн болоогүй эсхүл найдвартай биш гэж үзсэн тохиолдолд АКТ нь маржины шаардлагаа тогтоохдоо ханшийг хэрхэн тооцоолдог вэ?

6.2.4 Ханшийн мэдээлэл бэлэн болоогүй эсхүл найдвартай биш үед маржины шаардлага болон ханш тооцоход ашигладаг загварчлалаа хэрхэн баталгаажуулдаг вэ? Баталгаажуулалтын хараат бус байдлыг хэрхэн хангадаг вэ?

Гол асуудал 3. АКТ нь анхны (эхлэлийн) маржинг тогтоохдоо эрсдэлд суурилсан загвар, параметр ашиглан оролцогч төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед позицийг нь хааж, сүүлчийн маржинг цуглуулах хооронд үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах хангалттай маржины шаардлага тавих. Ирээдүйн эрсдэлийн тархалтыг хамгийн багадаа 99 хувийн итгэлцлийн зэрэгтэйгээр тооцсоны үндсэн дээр анхны маржинг тогтоох. Багцын маржин тооцдог АКТ-ийн хувьд багц тус бүрийн ирээдүйн эрсдэлийн тархалтыг тооцоход энэхүү шаардлагыг хангах. Харин дэд багцын түвшинд эсвэл бүтээгдэхүүн тус бүрээр маржин тооцдог ҮЦТТТО нь ирээдүйн эрсдэлийн харгалзах тархалтуудыг тооцохдоо дээрх шаардлагыг биелүүлэх. Маржины загвар нь а) ҮЦТТТО-оор дамжин төлбөр тооцоо нь хийгдэж буй тухайн төрлийн бүтээгдэхүүний хаалт хийхэд эсвэл үр ашигтайгаар хеджинг хийхэд уламжлал болгож хэвшсэн цагийн бүсийн үнэлгээг ашиглах (мөн зах зээлийн онцгой нөхцөл байдал үүссэн үед), б) тухайн бүтээгдэхүүний эрсдэлийн хүчин зүйлс болон багцын үр дүнд хамааралтай зээлийн эрсдэлийг үнэлэх аргачлалтай байх, в) давтамжтай өөрчлөлт болон хэлбэлзлийг аль болох бодит, нарийвчилсан байдлаар багасгах.

Анхны маржины загвар

6.3.1 АКТ нь анхны маржинг тооцох ямар загвартай вэ? Үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлоход ашиглаж буй арга хэрэгсэлтэй холбогдуулан загварыг нарийвчлан тодорхойлно уу. Анхны маржин тооцоход ашиглаж буй загварынхаа цар хүрээг тодорхойлно уу?

6.3.2 Маржин тооцох загварчлалдаа ямар таамаглалууд оруулсан бэ?

6.3.3 АКТ нь маржин тооцох загварын үндсэн параметрууд болон өгөгдлийг хэрхэн тооцоолдог вэ? Тухайлбал, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хязгаар, итгэлцлийн интервал гэх мэт.

Хаалтын болон жишээ, загвар хугацаа

6.3.4 АКТ нь бүтээгдэхүүн бүрийн хувьд тохиромжтой хямдралын хугацааг хэрхэн тодорхойлдог вэ? Тухайлбал, АКТ нь мэдрэмтгий, онцгой зах зээлийн нөхцөлд болзошгүй төлбөрийн чадварын өсөлтийн хугацаануудыг хэрхэн тодорхойлдог вэ? Энэ шинжилгээнд ямар хүчин зүйлс нөлөөлдөг вэ /зах зээлийн төлбөрийн чадвар, зах зээлд оролцогчид төлбөрийн чадваргүй байдал давамгайлах, позицийн төвлөрлийн сөрөг нөлөөлөл, АКТ-ийн хеджинг хийх бололцоо/?

6.3.5 АКТ нь маржины загвартаа ашиглаж буй түүхэн мэдээллийн тохиромжтой хугацааг хэрхэн тодорхойлдог вэ? Ямар хүчин зүйлсийг харгалзан үздэг бэ? Жишээлбэл, үнэ ханшийн өнгөрсөн хугацааны болон шинэ үүссэн хэлбэлзэл, түүхэн мэдээлэл төдийлөн байхгүй шинэ бүтээгдэхүүний хувьд загварчилан тооцсон мэдээлэл гэх мэт.

6.3.6 Яаралтай төлбөр барагдуулалт болон үнэ ханшийн сөрөг нөлөөллийн хоорондох арилжаанд АКТ нь хэрхэн анхаарал хандуулдаг вэ?

Эдийн засгийн төлөв байдал ба олгосон маржины чанар муудах эрсдэл

6.3.7 АКТ нь маржин тооцох аргачлалаа эдийн засгийн төлөв байдалтай хэрхэн уялдуулдаг бэ? Ялангуяа, АКТ нь эдийн засгийн төлөв байдлын нааштай өөрчлөлтийн тогтворгүйжилтийг хязгаарласан маржины шаардлага тавьдаг уу?

6.3.8 АКТ нь олгосон маржины чанар муудах эрсдэлийг хэрхэн тодорхойлж, бууруулдаг вэ?

Гол асуудал 4. АКТ нь үүссэн эрсдэлийн даамжрахыг хязгаарлахын тулд оролцогчийн позицгийг хамгийн наад зах нь өдөр бүр зах зээлийн үнээр үнэлж, хэлбэлзлийн маржин тооцдог байх. АКТ нь оролцогчдоос маржинаа нэмэгдүүлэхийг болон төлбөр хийхийг шаардах эрх мэдэл, үйл ажиллагааны чадавхтай байх.

6.4.1 АКТ нь хэлбэлзлийн маржин тооцох ямар загварчлал ашигладаг вэ? Үүссэн эрсдэлийг үнэлэх арга хэрэгсэл, зах зээлийн үнэлгээг хийх давтамж, маржин цуглуулах хуваарь, маржин нэмэгдүүлэх шаардлага зэрэгтэй холбогдуулан маржины тооцох загварчлалаа нарийвчлан тайлбарлана уу.

6.4.2 АКТ нь анхны болон хэлбэлзлийн маржинтай холбоотойгоор маржин нэмэгдүүлэхийг шаардах эрх мэдэл, үйл ажиллагааны чадавхтай юу?

Гол асуудал 5. Хэрэв тухайн бүтээгдэхүүний эрсдэл нь бусад бүтээгдэхүүний эрсдэлтэй шууд хамааралтай байгаа бол АКТ нь маржины шаардлага тооцохдоо өөрөө болон

бусад АКТ-ийн клиринг хийж буй бүтээгдэхүүнд тавьж буй маржинг тэнцвэржүүлэх эсвэл бууруулахыг зөвшөөрч болно. Хоёр ба түүнээс дээш АКТ-д кросс маржины үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрч байгаа бол тэдгээр АКТ нь зохих хамгаалалт, эрсдэлийн удирдлагын системтэй байх.

Багцын маржин

6.5.1 АКТ нь өөрөө болон бусад АКТ-ийн клиринг хийж буй бүтээгдэхүүнд шаардлагатай маржинг тэнцвэржүүлэх эсхүл бууруулахыг зөвшөөрдөг үү? Хэрэв тийм бол тухайн бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэл бусад бүтээгдэхүүний эрсдэлтэй харилцан хамааралтай байна уу? АКТ нь шаардлагатай маржинг хэрхэн тэнцвэржүүлж эсвэл бууруулдаг вэ?

6.5.2 АКТ нь бүтээгдэхүүний болон багцын түвшинд ирээдүйн болзошгүй эрсдэлийг хэрхэн тодорхойлж, үнэлдэг вэ? Клиринг хийж буй бүтээгдэхүүнийхээ шаардлагатай маржинг тэнцвэржүүлэх эсвэл бууруулахыг АКТ нь багцын маржины аргачлалдаа хэрхэн авч үзсэн бэ?

Кросс маржин

6.5.3 Хоёр ба түүнээс дээш АКТ-ийн хооронд кросс маржин тооцох тохиолдолд АКТ-үүдтэй эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг хэрхэн тохиролцдог вэ? Кросс маржиныг зохицуулсан үйл ажиллагааны болон хууль, эрх зүйн ямар зохицуулалт байна вэ?

Аргачлалын найдвартай байдал

6.5.4 АКТ нь багцын болон кросс маржин тооцох аргачлалынхаа найдвартай байдлыг хэрхэн баталгаажуулдаг вэ? АКТ нь аргачлалаараа үнийн хамаарлын түвшин болон зах зээлийн мэдрэмтгий байх үеийн тогтвортой байдлыг хэрхэн авч үздэг вэ?

Гол асуудал 6. АКТ нь буцаан шалгах шалгалт (backtesting)-ыг өдөр бүр, мэдрэмтгий байдлын шинжилгээг хамгийн багадаа сар тутам, шаардлагатай гэж үзвэл илүү богино хугацаанд нарийвчлан хийх замаар маржины загварынхаа гүйцэтгэл, найдвартай байдалд дүн шинжилгээ хийн, хяналт тавих. АКТ нь клиринг хийж буй бүтээгдэхүүн бүрийн хувьд маржины загварын онолын ба эмпирик үнэлгээг тогтмол хийж байх. АКТ нь мэдрэмтгий байдлын шинжилгээ хийхдээ зах зээл нэлээд тогтворгүй байх үеийн болон үнийн хэт өсөлт, бууралт үзүүлсэн нөхцөл байдлыг тусгасан параметр, таамаглалд анхаарал хандуулах.

Буцаан шалгах шалгалт ба мэдрэмтгий байдлын шинжилгээ

6.6.1 Зорилтот итгэлцлийн түвшин болон нийт маржины үр дүн зэргийг оруулан буцаан шалгах аргачлал болон загварын гүйцэтгэлийг нарийвчлан тодорхойлно уу. Буцаан шалгах шалгалтыг хэр тогтмол хийдэг вэ?

6.6.2 Анхны маржин тогтоох аргачлал болон загварын гүйцэтгэлд хийдэг мэдрэмтгий байдлын шинжилгээний талаар нарийвчлан тайлбарлана уу. Уг шинжилгээгээр янз бүрийн параметр, таамаглал, зах зээлийн түүхэн болон онолын нөхцөл байдал, оролцогчийн позиц, мэдрэмтгий байдал зэргийг авч үздэг үү?

Маржин тооцох загварын гүйцэтгэл

6.6.3 Маржин тооцох загварт буцаан шалгах шалгалт болон мэдрэмтгий байдлын шинжилгээгээр илэрсэн ямар болзошгүй дутагдал байна вэ?

6.6.4 Хэрэв тухайн загварыг ашигласнаар хүссэн үр дүнд хүрээгүй тохиолдолд АКТ нь ямар арга хэмжээ авах вэ?

6.6.5 Буцаан шалгах шалгалт болон мэдрэмтгий байдлын шинжилгээний үр дүнг АКТ нь хэрхэн тайлагнадаг вэ?

Гол асуудал 7. АКТ нь маржины системээ тогтмол үнэлж, хянан, баталгаажуулдаг байх.

6.7.1 АКТ нь маржины системээ онолын болон туршилтын онцлог зэргийг харгалзан хэрхэн үнэлж, хянаж, баталдаг вэ? Ийм үнэлгээ, хяналт, баталгаажуулалтыг хэр тогтмол хийдэг вэ?

6.7.2 АКТ нь маржин тооцох аргачлалд орсон томоохон өөрчлөлт, тохиргоог удирдлага зохион байгуулалтын түвшинд хэрхэн авч үздэг вэ?

6.7.3 АКТ нь энэхүү хяналт, үнэлгээ, баталгаажуулалтын арга аргачлал, үр дүнгийн талаар хэнд, хэрхэн мэдээлдэг вэ?

Зарчим 7. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл

Дэд бүтэц нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ бодитоор үнэлж, хянаж, удирдах шаардлагатай. Дэд бүтэц нь зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн оролцогч, түүний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох зэрэг болзошгүй нөхцөл байдал үүссэн үед ч тухайн өдөр боловсруулсан гүйлгээний төлбөр тооцоог аль болох өдөрт нь багтаан найдвартай хийхийн тулд төлбөр тооцоонд ашиглагдаж буй валют бүрээр хангалттай хэмжээний түргэн хөрвөх эх үүсвэр байршуулах нь зүйтэй.

Гол асуудал 1. Оролцогч, төлбөр тооцооны банк, ностро банк, кастодиан банк, эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллага болон холбогдох бусад этгээдийн үйл ажиллагаанаас үүдэн учирч болзошгүй төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг удирдах найдвартай тогтолцоотой байх.

7.1.1 Оролцогч, төлбөр тооцооны банк, ностро банк, кастодиан банк, эх үүсвэр зээлдүүлэгч байгууллага болон холбогдох бусад этгээдийн үйл ажиллагаанаас үүдэн учирч болзошгүй төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг удирдах ямар тогтолцоотой вэ?

7.1.2 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгцээ, холбогдох эрсдэлийн хүчин зүйлсийг хэрхэн тогтоодог вэ?

7.1.3 Оролцогчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт үүсэж болзошгүй хүндрэлд хэрхэн анхаарал хандуулдаг вэ?

Гол асуудал 2. Төлбөр тооцооны болон мөнгөн хөрөнгийн урсгал, өдрийн туршид шаардагдаж буй төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгцээ зэргийг тогтмол тухай бүр нь тодорхойлж, үнэлж, хянах үйл ажиллагааны болон дүн шинжилгээний үр дүнтэй арга хэрэгслүүдтэй байх.

7.2.1 Төлбөр тооцооны болон мөнгөн хөрөнгийн урсгалыг тодорхойлж, үнэлж, хянах үйл ажиллагааны болон дүн шинжилгээний ямар арга хэрэгслүүдтэй вэ?

7.2.2 Төлбөр тооцооны болон мөнгөн хөрөнгийн урсгал, өдрийн туршид шаардагдаж буй төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгцээ зэргийг тогтмол тухай бүр нь тодорхойлж, үнэлж, хянахдаа тэдгээр арга хэрэгслээ хэрхэн ашигладаг вэ?

Гол асуудал 3. Тогтоосон хугацаанд үр дүнгийн тооцоо хийдэг төлбөр тооцооны системийн хувьд зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн оролцогч, түүний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох зэрэг болзошгүй нөхцөл байдалд тухайн өдрийн болон хэд хэдэн өдрийн төлбөр тооцоог аль болох өдөрт нь багтаан найдвартай хийхийн тулд түргэн хөрвөх хангалттай эх үүсвэртэй байх.

7.3.1 Тухайн өдрийн болон хэд хэдэн өдрийн төлбөр тооцоог аль болох өдөрт нь багтаан найдвартай хийхийн тулд шаардлагатай эх үүсвэрийн хэмжээг хэрхэн тодорхойлдог вэ? Энэ эх үүсвэрийн хэмжээг тодорхойлоход ямар болзошгүй нөхцөл байдал (зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн оролцогч, түүний охин компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох зэрэг)-ыг харгалзан үздэг вэ?

7.3.2 Хэдий хэмжээний эх үүсвэрийн хомсдол байна вэ?

Гол асуудал 4. АКТ нь болзошгүй нөхцөл байдал үүссэн үед үнэт цаасны төлбөр тооцоо, маржин болон бусад төлбөрийг цаг хугацаанд нь найдвартай гүйцэтгэхийн тулд түргэн хөрвөх хангалттай хэмжээний валютын эх үүсвэртэй байх. Тухайлбал, зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед оролцогч, түүний салбар компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болж болох юм. Түүнчлэн, илүү эрсдэл бүхий үйл ажиллагаа явуулдаг, хэд хэдэн улс оронд системийн хувьд нэн чухлаар тооцогддог АКТ-ийн хувьд төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн хоёр оролцогч, тэдний салбар компаниуд зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед үүргээ биелүүлэх боломжгүй болж болох зэрэг болзошгүй нөхцөл байдлаас хамгаалах хангалттай хэмжээний нэмэлт эх үүсвэртэй байх.

Түргэн хөрвөх эх үүсвэрийн хүрэлцээтэй байдал

7.4.1 Болзошгүй нөхцөл байдал үүссэн үед үнэт цаасны төлбөр тооцоо, маржин болон бусад төлбөрийг цаг хугацаанд нь найдвартай гүйцэтгэхийн тулд АКТ нь түргэн хөрвөх хангалттай хэмжээний валютын эх үүсвэрийн хэмжээг хэрхэн тодорхойлдог вэ? Ингэж тодорхойлохдоо АКТ нь болзошгүй ямар нөхцөл байдлыг харгалзан үздэг вэ? Тухайлбал, зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн оролцогч, түүний салбар компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болох гэх мэт.

7.4.2 Зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед оролцогч, түүний салбар компаниуд үүргээ биелүүлэх боломжгүй болсноос үүдэн АКТ нь шаардлагатай валют бүрээр хэдий хэмжээний төлбөрийн чадварын дутагдалд орох тооцоололтой байна вэ? АКТ нь ийм тооцооллыг хэр тогтмол хийдэг вэ?

Эрсдэлийн түвшин ба системийн хувьд ач холбогдол бүхий байдал

7.4.3 АКТ нь илүү эрсдэл бүхий үйл ажиллагаа явуулдаг уу? АКТ нь хэд хэдэн улс оронд системийн хувьд ач холбогдолтой гэж тооцогддог уу?

7.4.4 Хэрэв АКТ нь илүү эрсдэлтэй үйл ажиллагаа эрхэлдэг эсхүл хэд хэдэн улс оронд системийн хувьд ач холбогдолтой гэж тооцогддог бол зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед төлбөрийн томоохон үүрэг хүлээсэн хоёр оролцогч, тэдний салбар компаниуд үүргээ

биелүүлэх боломжгүй болох зэрэг эрсдэлээс хамгаалах хангалттай нэмэлт эх үүсвэр байршуулах талаар бодолцон үзсэн үү?

Гол асуудал 5. Заавал байлгах түргэн хөрвөх эх үүсвэрийн шаардлагаа хангах зорилгоор төлбөр тооцоонд ашиглагдаж буй валют бүрээр эх үүсвэр бүрдүүлэхдээ зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед ч шууд ашиглаж, мөнгөн хөрөнгөд хөрвүүлэх боломжтой хөрөнгө (тухайн валютыг гаргасан төв банк болон зээлжих чадвар бүхий арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хөрөнгө, зээлийн шугам, гадаад валютын своп хэлцэл, репо хэлцэл, кастодиан банкинд байршуулсан түргэн борлогдох барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалт зэрэг)-ийг сонгох нь зүйтэй. Хэрэв тухайн валютыг гаргагч төв банкнаас зээл авах боломжтой бол үүнийг тухайн төв банкны хүлээн зөвшөөрөх барьцааг барьшуулан заавал байлгах нөөцөө нэмэгдүүлэх боломж гэж үзэж болно. Эдгээр эх үүсвэрийг шаардлагатай тохиолдолд ашиглахад бэлэн байлгах.

Түргэн хөрвөх эх үүсвэрийн хэлбэр, хэмжээ

7.5.1 Төлбөр тооцоонд ашиглагдаж буй тухайн валют бүрээр бүрдүүлсэн хэдий хэмжээний, ямар хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх эх үүсвэр байна вэ? Тухайн эх үүсвэрийг хэдийд, хэрхэн ашиглах боломжтой вэ?

Түргэн хөрвөх эх үүсвэрийн ашиглалт, бүрдүүлэлт

7.5.2 Шууд удирдах боломжтой барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалтыг мөнгөн хөрөнгөд хөрвүүлэхтэй холбоотой ямар зохицуулалтууд байна вэ? Зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед ч гэсэн тэдгээрийг найдвартай хэрэгжүүлэх боломжийг хэрхэн бүрдүүлсэн бэ? Тухайн эх үүсвэрийг удирдахтай холбогдсон ямар нэгэн саад бэрхшээл байна уу?

7.5.3 Хэрэв тухайн валютыг гаргагч төв банкнаас зээл авах боломжтой бол энэхүү валютаар заавал байлгах эх үүсвэр бүрдүүлэхэд хэдий хэмжээний зээл авах бололцоотой вэ?

7.5.4 Төлбөр тооцоог тогтоосон хугацаанд хийхэд тухайн валютаарх заавал байлгах эх үүсвэрийг өөрийн эх үүсвэрээр бүрдүүлэх хэр боломжтой вэ?

Гол асуудал 6. Заавал байлгах түргэн хөрвөх үүсвэрээ бусад хэлбэрийн түргэн хөрвөх эх үүсвэрээр бүрдүүлж болно. Хэдийгээр зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед найдваргүй байж болох ч ийм хэлбэрээр эх үүсвэрээ бүрдүүлж байгаа бол оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд тэдгээр хөрөнгийг зээл, своп болон репо хэлцлийн барьцаанд тодорхой хугацаанд тавих эхсүл амархан худалдан борлуулж болохуйц байх ёстой. Төв банкнаас зээл авах боломжгүй байлаа ч ерөнхийдөө ямар хөрөнгийг барьцаанд хүлээн зөвшөөрдөг болохыг мэдэж байх нь зүйтэй бөгөөд онцгой нөхцөл байдал үүссэн үед тэдгээр хөрөнгө нь илүү түргэн хөрвөх боломжтой байж болох юм. Яаралтай тохиолдолд төв банкнаас зээл авах боломжийг төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах арга хэрэгсэл гэж үзэхгүй байвал зохино.

Түргэн хөрвөх нэмэлт эх үүсвэрийн хэлбэр, хэмжээ

7.6.1 Хэдий хэмжээний, ямар хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх нэмэлт эх үүсвэр байна вэ?

Түргэн хөрвөх нэмэлт эх үүсвэрийн ашиглалт

7.6.2 Хэдийгээр зах зээлийн онцгой нөхцөл байдлын үед энэ нь найдваргүй байж болох ч шаардлагатай валютын эх үүсвэрийг бүрдүүлэх үүднээс тэдгээр хөрөнгийг худалдан борлуулах, барьцаанд байршуулах боломжийг юунд үндэслэн хэрхэн тодорхойлж байна вэ?

7.6.3 Тэдгээр нэмэлт эх үүсвэрээс хэдий хэрийг нь төв банкинд барьцаа хэлбэрээр байршуулах боломжтой вэ?

7.6.4 Ямар нөхцөлд энэхүү түргэн хөрвөх нэмэлт эх үүсвэрийг ашигладаг вэ?

7.6.5 Түргэн хөрвөх эх үүсвэрийнхээ хүрэлцээтэй байдлыг тодорхойлохдоо мэдрэмтгий байдлын шинжилгээгээр тогтоосон эх үүсвэрийн хэрэгцээний хэдий хэрийг нь нэмэлт эх үүсвэрээр бүрдүүлж байна вэ? Гол асуудал 9-ийг харна уу.

Гол асуудал 7. Заавал байлгах түргэн хөрвөх эх үүсвэр байршуулахдаа тухайн этгээд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ тодорхойлж, удирдах хангалттай мэдээлэлтэй эсэх, мөн хүлээсэн үүргээ биелүүлэх санхүүгийн чадавхтай эсэхийг нь сайтар танин мэдэж, итгэл хүлээлгэх хэрэгтэй. Түүнчлэн, эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагынхаа төв банкнаас зээл авах боломжийг нь авч хэлэлцэх. Эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллага дахь түргэн хөрвөх эх үүсвэрийг ашиглах зохицуулалтад тогтмол хяналт тавих.

Эх үүсвэр байршуулсан банк, санхүүгийн байгууллагууд

7.7.1 Заавал байлгах түргэн хөрвөх эх үүсвэрийн шаардлагыг хангахын тулд эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагад ханддаг уу? Ямар банк, санхүүгийн байгууллагатай энэ зорилгоор хамтран ажиллаж байна вэ? Онцгой нөхцөл байдлын үед ч тухайн банк, санхүүгийн байгууллага холбогдох валют бүрээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ тодорхойлж, удирдах хангалттай мэдээлэлтэй гэдгийг хэрхэн, юунд үндэслэн тодорхойлж байна вэ?

Эх үүсвэр байршуулсан банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны найдвартай байдал

7.7.2 Эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагын хүлээсэн үүргээ биелүүлэх санхүүгийн чадавхтай эсэхийг хэрхэн тодорхойлдог вэ?

7.7.3 Эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллагынхаа төв банкнаас зээл авах боломжийг хэрхэн авч үздэг вэ?

7.7.4 Эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллага дээрх түргэн хөрвөх эх үүсвэрийг ашиглах зохицуулалтын үнэн зөв, цагаа олсон эсэхэд хэрхэн хяналт тавьдаг вэ?

Гол асуудал 8: Төв банкинд харилцах данстай бөгөөд төлбөрийн болон үнэт цаасны үйлчилгээг нь авдаг бол дэд бүтэц нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлагаа сайжруулахын тулд энэ төрлийн үйлчилгээг аль болох түлхүү ашиглах.

7.8.1 Төлбөр тооцоо гүйцэтгэх, төлбөр тооцоонд ашиглаж буй валют бүрээрх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг удирдахад ашиглаж болохуйц харилцах дансыг төв банкинд нээлгэсэн эсэх, үзүүлж буй төлбөр тооцооны үйлчилгээг нь авдаг эсэх? Данс нээлгэх, тэдгээр үйлчилгээг авах боломж байна уу?

7.8.2 Төлбөр тооцоо гүйцэтгэх, холбогдох валют бүрээрх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ удирдахад төв банкууд дээрх тэдгээр үйлчилгээг хэр зэрэг ашигладаг вэ?

7.8.3 Төв банкны үйлчилгээг ашигладаггүй бол тэдгээрийг авснаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлагыг сайжруулах боломжийг хэр зэрэг судалсан бэ?

7.8.4 Төв банкнаас үзүүлж буй өөр бусад үйлчилгээг ашиглах талаар ямар байр суурьтай байна вэ?

Гол асуудал 9. Мэдрэмтгий байдлын нарийвчилсан шинжилгээгээр түргэн хөрвөх эх үүсвэрийнхээ хэмжээг тодорхойлж, хүрэлцээтэй байдлыг нь тогтмол хянах. Шинжилгээний үр дүнг шийдвэр гаргах түвшний холбогдох албан тушаалтанд тайлагнаж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо үнэлж, бэхжүүлэхэд энэхүү шинжилгээний үр дүнг ашиглах тодорхой зохицуулалттай байх. Мэдрэмтгий байдлын шинжилгээ хийхдээ болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Болзошгүй нөхцөл байдал гэдэгт ерөнхийдөө зах зээлийн онцгой нөхцөл байдлын үе дэх үнийн түүхэн дээд хэлбэлзлүүд, үнэ тодорхойлогч болон өгөөжийн муруй зэрэг зах зээлийн бусад хүчин зүйлсийн шилжилт хөдөлгөөн, оролцогчид хэд хэдээрээ үүргээ биелүүлэх боломжгүй болоход хүрсэн тохиолдлууд, хөрөнгө санхүүжилтийн шат дараалсан хүндрэлүүд болон урьдчилан таамагласан янз бүрийн нөхцөл байдлыг ойлгоно. Түүнчлэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын томоохон эрсдэлд оруулж болзошгүй бусад этгээд (төлбөр тооцооны банк, ностро банк, кастодиан банк, эх үүсвэрээ байршуулсан банк, санхүүгийн байгууллага, хамтран ажиллаж буй бусад дэд бүтэц зэрэг)-ийн үйл ажиллагаанд анхаарал хандуулах. Ямар ч тохиолдолд түргэн хөрвөх нийт эх үүсвэрийнхээ хэлбэр, хэмжээг баталгаажуулан баримтжуулж, тэдгээрийг удирдахтай холбогдсон удирдлагын түвшний тодорхой зохицуулалттай байх.

Мэдрэмтгий байдлын шинжилгээ

7.9.1 Төлбөр тооцоонд ашиглагдаж буй валют бүрээрх түргэн хөрвөх эх үүсвэрийн хэмжээг тодорхойлж, хүрэлцээтэй байдлыг нь хянахад мэдрэмтгий байдлын шинжилгээг хэрхэн ашигладаг вэ?

7.9.2 Түргэн хөрвөх эх үүсвэрийн хэмжээ, бүтэц бүрэлдэхүүн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо үнэлж, цагаа олсон шаардлагатай арга хэмжээг авах зорилгоор түргэн хөрвөх эх үүсвэртээ хийсэн мэдрэмтгий байдлын шинжилгээний үр дүнг шийдвэр гаргах түвшний холбогдох албан тушаалтанд ямар хэлбэрээр тайлагнадаг вэ?

Мэдрэмтгий байдлын шинжилгээгээр харгалзан үзэх нөхцөл байдал

7.9.3 Мэдрэмтгий байдлын шинжилгээнд болзошгүй ямар нөхцөл байдлыг харгалзан үздэг вэ? Зах зээлийн онцгой нөхцөл байдлын үе дэх үнийн түүхэн дээд хэлбэлзлүүд, үнэ тодорхойлогч болон өгөөжийн муруй зэрэг зах зээлийн бусад хүчин зүйлсийн шилжилт хөдөлгөөн, оролцогчид хэд хэдээрээ үүргээ биелүүлэх боломжгүй болоход хүрсэн тохиолдлууд, хөрөнгө санхүүжилтийн шат дараалсан хүндрэлүүд болон урьдчилан таамагласан янз бүрийн нөхцөл байдал зэрэгт хэр анхаарал хандуулдаг вэ?

7.9.4 Нөхцөл байдлын болон мэдрэмтгий байдлын шинжилгээ (scenarios and stress tests)-г төлбөр тооцоо гүйцэтгэж буй хэлбэр (жишээ нь, гүйлгээг нэг бүрчлэн болон нэгтгэн боловсруулах, ҮЦТТС дэх төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн зарчим (DvP) 1, 2, 3-ыг ашиглах), оролцогчид болон дэд бүтцийн өөрийнх нь бий болгож буй төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлд хэр зэрэг анхаарал хандуулдаг вэ?

7.9.5 Нөхцөл байдлын болон мэдрэмтгий байдлын шинжилгээгээр төлбөр тооцоог тогтсон цагт нь хийх, оролцогчид, тэдний охин компаниуд үүргээ гүйцэтгэх боломжгүй болох зэрэгтэй холбогдон үүсэх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хэрэгцээ, шаардлага, холбогдох эрсдэлийн хүчин зүйлсэд хэр зэрэг анхаарал хандуулдаг вэ?

Үнэлгээ, баталгаажуулалт

7.9.6 Мэдрэмтгий байдлын шинжилгээ хийхэд дэвшүүлж буй таамаглал, ашиглаж буй параметрийн үр ашигтай, оновчтой байдлыг хэр тогтмол үнэлдэг вэ? Мэдрэмтгий байдлын шинжилгээгээр позиц болон үнийн хэлбэлзлийн гэнэтийн томоохон өсөлт бий болох, позицийн хэт төвлөрөл үүсэх, зах зээл дээрх хөрөнгийн эрэлт хэрэгцээ өөрчлөгдөх зэрэг янз бүрийн нөхцөл байдлыг хэрхэн авч үздэг вэ?

7.9.7 Эрсдэлийн удирдлагын загвараа хэрхэн үнэлж баталгаажуулдаг вэ? Ийм баталгаажуулалтыг хэр тогтмол хийдэг вэ?

7.9.8 Түргэн хөрвөх нийт эх үүсвэрийн хэлбэр, хэмжээг хэрхэн баталгаажуулдаг вэ? Тэдгээрийг удирдахтай холбогдсон удирдлагын түвшний ямар зохицуулалт байна вэ?

Гол асуудал 10. Тухайн нэг эсхүл хэсэг бүлэг оролцогч төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болсон ч тухайн өдөр эсвэл хэд хэдэн өдрийн төлбөр тооцоог аль болох өдөрт нь багтаан хийхтэй холбоотой асуудлыг зохицуулсан тодорхой дүрэм, журамтай байх. Эдгээр дүрэм, журмаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварын урьдчилан таамаглаагүй болзошгүй хүндрэлийг шийдвэрлэж, төлбөр тооцоог хойшлуулах, цуцлах зэрэг асуудлаас зайлсхийх хэрэгтэй. Түүнчлэн, үйл ажиллагааныхаа найдвартай, тогтвортой байдлыг хангах зорилгоор онцгой тохиолдолд дайчлах түргэн хөрвөх эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэлбэрүүдийг тэдгээр дүрэм, журмаар тодорхойлох.

Төлбөр тооцоог тухайн өдөрт нь багтаан хийх

7.10.1 Оролцогчид дотроос тухайн нэг эсхүл хэсэг бүлэг оролцогч төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед төлбөр тооцоог тогтсон хугацаанд хийх бололцоог дүрэм, журмаараа хэрхэн хангасан бэ?

7.10.2 Эдгээр дүрэм, журмаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварын урьдчилан таамаглаагүй болзошгүй хүндрэлийг хэрхэн шийдвэрлэж, төлбөр тооцоог хойшлуулах, цуцлах зэрэг асуудлаас хэрхэн сэргийлж чадсан бэ?

Түргэн хөрвөх эх үүсвэрийг нэмэгдүүлэх

7.10.3 Онцгой тохиолдолд дайчлах санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх талаар ямар дүрэм, журамд хэрхэн тусгасан бэ?

Зарчим 8. Төлбөр тооцоог эцэслэх

Дэд бүтэц нь төлбөр тооцоог хамгийн цаад тал нь тухайн өдрийн эцэс гэхэд гүйцэтгэсэн байх ёстой. Шаардлагатай эсхүл боломжтой тохиолдолд төлбөр тооцоог тухайн өдөрт нь багтаан эсхүл бодит цагийн горимоор гүйцэтгэж байх нь зүйтэй.

Гол асуудал 1. Төлбөр тооцоо хэзээ эцсийн болох талаар дүрэм, журамдаа тодорхой зааж өгөх.

Төлбөр тооцоог эцэслэх мөч

8.1.1 Төлбөр тооцоо хэзээ эцсийн болж, үл буцаагдах, нөхцөлт бус байдал бий болох вэ? Төлбөр тооцоог эцсийн байхыг тодорхойлж, холбогдох баримт бичигт тусгасан уу? Энэ талаарх мэдээллийг хэнд, хэрхэн өгдөг вэ?

8.1.2 Дүрэм, журам, эрх зүйн баримт бичгийнхээ хүрээнд оролцогч талтай хийж буй төлбөр, шилжүүлгийн даалгавар буюу бусад төлбөрийн баримтын гүйцэтгэлийг хэрхэн баталгаажуулдаг вэ?

8.1.3 Төлбөр тооцоог эцэслэхтэй холбоотой хууль эрх зүйн үндэслэл сайтар бүрдсэн гэдгийг хэрхэн харуулах вэ?

Хамтын ажиллагаа бүхий төлбөр тооцооны системтэй холбоотой төлбөр тооцоог эцэслэх

8.1.4 Хамтран ажиллаж буй төлбөр тооцооны системтэй холбоотой төлбөр тооцоог эцэслэх нөхцөлийг хэрхэн хангадаг бэ?

Гол асуудал 2. Төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах үүднээс эцсийн төлбөр тооцоог өдөрт нь багтаан, боломжтой бол бодит цагийн горимоор хийх. Их дүнтэй төлбөр тооцооны системийн хувьд RTGS систем эсхүл хэд хэдээр нь багцлан дамжуулж төлбөр тооцоог өдрийн туршид гүйцэтгэхэд анхаарал хандуулах.

Эцсийн төлбөр тооцоог тухайн өдөрт нь багтаан хийх

8.2.1 Төлбөр тооцоог тухайн өдөрт нь багтаан хийдэг үү? Төлбөр хийгдэх өдрийн эцэс гэхэд эцсийн төлбөр тооцоог хийсэн байх нөхцөлийг хэрхэн хангасан бэ?

8.2.2 Дүрэм, журам, гэрээгээ зөрчин эцсийн төлбөр тооцоог дараагийн ажлын өдөр гүйцэтгэсэн тохиолдол үүсэж байсан уу? Хэрэв тийм бол ямар нөхцөл байдлын улмаас ийм шаардлага үүссэн бэ? Ирээдүйд иймэрхүү нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх ямар арга хэмжээ аваад байна вэ?

Эцсийн төлбөр тооцоог өдөрт нь багтаан эсхүл бодит цагийн горимоор гүйцэтгэх

8.2.3 Эцсийн төлбөр тооцоог өдөрт нь багтаан эсвэл бодит цагийн горимоор хийдэг үү? Хэрэв тийм бол хэрхэн хийдэг вэ? Оролцогчдод үр дүнгийн тооцооны талаар хэрхэн мэдэгддэг вэ?

8.2.4 Хэрэв төлбөр тооцоог хэд хэдээр нь багцлан гүйцэтгэдэг бол цаг хугацааны хувьд ямар давтамжтайгаар хийдэг вэ? Төлбөр тооцоог хийх тухайн үед оролцогчид хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгө эсхүл үнэт цаас байхгүй тохиолдолд ямар нөхцөл байдал үүсэх вэ? Гүйлгээнүүдийг дараагийн багцад оруулдаг уу? Хэрэв тийм бол тэдгээр гүйлгээг ямар төлөвт байна гэж үзэж, хэзээ эцэслэн гүйцэтгэх вэ?

8.2.5 Хэрэв төлбөр тооцоог өдөрт нь багтаан эсхүл бодит цагийн горимоор гүйцэтгэдэггүй бол их дүнтэй төлбөр тооцооны системдээ эдгээрийн аль нэгийг нэвтрүүлэх талаар ямар байр суурьтай байна вэ?

Гол асуудал 3. Төлбөр тооцоо нь хийгдээгүй төлбөр, шилжүүлгийн даалгаврыг оролцогчийн зүгээс хэдийнээс цуцлах боломжгүй болохыг тодорхойлж өгөх.

8.3.1 Төлбөр тооцоо нь хийгдээгүй гүйлгээг оролцогчийн зүгээс хэдийнээс цуцлах боломжгүй болохыг хэрхэн тодорхойлж өгсөн бэ? Хүлээн авсан болон төлбөр тооцоо нь хийгдээгүй төлбөр, шилжүүлгийг тухайн мөчөөс хойш нэг талын санаачилгаар цуцлах боломжийг хэрхэн хаасан вэ?

8.3.2 Ямар нөхцөлд төлбөр тооцоог нь хийхээр системд хүлээн авсан төлбөр, шилжүүлгийг буцаан дуудах боломжтой вэ? Жишээ нь, дараалалд орсон төлбөрийн даалгаврууд. Төлбөр тооцоо нь хийгдээгүй төлбөрийн даалгаврыг хэрхэн буцаан дуудаж болох вэ? Ямар албан тушаалтан хийгдээгүй төлбөр, төлбөрийн даалгаврыг буцаан дуудаж болох вэ?

8.3.3 Ямар нөхцөлд гүйлгээг буцаан дуудах хугацааг сунгахыг зөвшөөрдөг вэ?

8.3.4 Энэ талаарх мэдээллийг ямар баримт бичигт тусгасан бэ? Энэхүү мэдээллийг хэнд, хэрхэн өгдөг вэ?

Зарчим 9. Мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоо

Дэд бүтэц нь аль болох төв банкин дахь мөнгөн хөрөнгөө ашиглан төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Төв банкин дахь мөнгөн хөрөнгийг ашигладаггүй тохиолдолд арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгөө ашигласнаас үүсэж болзошгүй зээлийн болон төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулж, хатуу хяналт тавих шаардлагатай.

Гол асуудал 1. Зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээс зайлсхийх үүднээс аль болох төв банкин дахь мөнгөн хөрөнгийг ашиглан мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоог гүйцэтгэх.

9.1.1 Мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоог хэрхэн гүйцэтгэдэг вэ?

9.1.2 Хэрэв үр дүнгийн тооцоо хийхдээ төв банкин дахь мөнгөн хөрөнгөө ашигладаггүй бол яагаад тэр вэ?

Гол асуудал 2. Төлбөр тооцоонд төв банкин дахь мөнгөн хөрөнгөө ашигладаггүй бол зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлд аль болох өртөхөөргүй эх үүсвэрийг ашиглан мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоог гүйцэтгэх.

9.2.1 Төлбөр тооцоонд төв банкин дахь мөнгөн хөрөнгөө ашигладаггүй бол мөнгөн хөрөнгөөр хийх төлбөр тооцоонд ашиглаж буй эх үүсвэрийнхээ зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг хэрхэн үнэлдэг вэ?

9.2.2 Хэрэв төлбөр тооцоо хийхэд арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгөө ашигладаг бол төлбөр тооцооны банкаа хэрхэн сонгодог вэ? Сонгон шалгаруулалтын ямар ямар шаардлага, шалгуур тавьдаг вэ?

Гол асуудал 3. Арилжааны банкин дахь мөнгөөр төлбөр тооцоо хийдэг бол тухайн төлбөр тооцооны банктэй холбоотойгоор үүсэж болзошгүй зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг хянаж, удирдаж, хязгаарлах. Ялангуяа, төлбөр тооцооны банкныхаа төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон үйл ажиллагааны найдвартай байдал, эх үүсвэрийн хүрэлцээ, хөрөнгийн хэмжээ, зээлжих чадвар, хяналт

зохицуулалт зэргийг хамарсан нарийвчилсан шаардлага, шалгуурыг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих. Түүнчлэн, төлбөр тооцооны банкуудад тулгарч буй зээлийн төвлөрлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлийг хянаж, удирдах.

9.3.1 Төлбөр тооцооны банкуудын холбогдох шаардлага, шалгуурыг хэрэгжүүлж буй байдалд хэрхэн хяналт тавьдаг вэ? Жишээ нь, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон үйл ажиллагааных нь найдвартай байдал, эх үүсвэрийнх нь хүрэлцээ, хөрөнгийн хэмжээ, зээлжих чадвар, хяналт зохицуулалт зэргийг нь хэрхэн үнэлдэг вэ?

9.3.2 Төлбөр тооцооны банкуудтай холбоотой зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг хэрхэн хянаж, удирдаж, хязгаарладаг вэ? Тэдгээр банкуудад тулгарч буй зээлийн төвлөрлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлийг хэрхэн хянаж, удирддаг вэ?

9.3.3 Төлбөр тооцооны хамгийн том банк нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд өөртөө болон оролцогчдод учирч болзошгүй хохирол, алдагдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлийг хэрхэн үнэлдэг вэ?

Гол асуудал 4. Дэд бүтэц нь өөрийнхөө бүртгэлд үндэслэн төлбөр тооцоо хийдэг бол зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ бууруулж, хатуу хяналт тавих.

9.4.1 Дэд бүтэц нь өөрийн бүртгэлд үндэслэн төлбөр тооцоо хийдэг бол зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ хэрхэн бууруулж, хяналт тавьдаг вэ?

Гол асуудал 5. Зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ удирдах үүднээс төлбөр тооцооны банкуудтай байгуулсан гэрээндээ шилжүүлэг хийгдсэн л бол эцсийн болох, хүлээн авсан хөрөнгийг шилжүүлэх боломжтой байх талаар тодорхой дурдах.

9.5.1 Төлбөр тооцооны банкуудтай байгуулсан гэрээндээ гүйлгээ хийгдсэн л бол эцсийн болох, мөн хүлээн авсан хөрөнгийг шууд шилжүүлэх боломжтой байх талаар дурдсан эсэх?

9.5.2 Хүлээн авсан хөрөнгийг хамгийн цаад тал нь тухайн өдрийн эцэс гэхэд шилжүүлсэн байх боломжтой юу? Үгүй бол яагаад? Тухайн хөрөнгийг өдрийн туршид шилжүүлэх боломжтой юу? Үгүй бол яагаад?

Зарчим 10. Биет хэлбэрээр нь хүргэх

Дэд бүтэц нь биет бараа, бүтээгдэхүүнийг хүргэхтэй холбоотойгоор гүйцэтгэх үүргийг тодорхой зааж, үүнээс учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдана.

Гол асуудал 1. Дэд бүтэц нь хэлцэл, бараа бүтээгдэхүүний биет хүргэлттэй холбоотойгоор хүлээх үүргээ тодорхой заах.

10.1.1 Дэд бүтэц нь ямар хөрөнгийн биет хүргэлт хийхийг хүлээн зөвшөөрдөг вэ?

10.1.2 Дэд бүтэц нь бараа, бүтээгдэхүүний биет хүргэлттэй холбоотойгоор хүлээх үүрэг, хариуцлагаа хэрхэн тодорхойлдог вэ? Тэдгээр үүрэг, хариуцлагын талаар ямар баримт бичигт хэрхэн тодорхойлж, хэнд энэ талаар мэдээлдэг вэ?

10.1.3 Дэд бүтэц нь биет хүргэлттэй холбоотойгоор хүлээх үүрэг, хариуцлагын талаар ойлголт өгөх зорилгоор оролцогчидтой хэрхэн тулж ажилладаг вэ?

Гол асуудал 2. Дэд бүтэц нь хэлцэл, бараа бүтээгдэхүүний хадгалалт, хүргэлттэй холбоотойгоор учирч болзошгүй эрсдэлүүд, гарах зардлыг тодорхойлох, хянах, удирдах.

10.2.1 Дэд бүтэц нь хэлцэл, бараа бүтээгдэхүүний хадгалалт, хүргэлттэй холбоотойгоор учирч болзошгүй эрсдэлийг хэрхэн тодорхойлдог вэ?

10.2.2 Дэд бүтэц нь хэлцэл, бараа бүтээгдэхүүний хадгалалт, хүргэлттэй холбоотой эрсдэл, өртөг зардлыг хянаж, удирдах ямар дүрэм, журамтай вэ?

10.2.3 Дэд бүтэц нь хэрэглэгчдэд хүргэлт болон хүлээн авалтыг холбодог бол ямар нөхцөлд үүнийг хийдэг, үүнтэй холбоотой ямар дүрэм, журам байна вэ? Хүргэлттэй холбоотой хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагын талаар холбогдох дүрэм, журам, гэрээнд тодорхой тусгасан уу?

10.2.4 Дэд бүтэц нь оролцогчдын хүргэлтийн явц, санхүүгийн үүргээ биетээр биелүүлэх шаардлагатай систем болон нөөцийг хэрхэн баталгаажуулдаг вэ?

Зарчим 11. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

ҮЦТХТ нь үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хангах, тэдгээрийг найдвартай хадгалах, хамгаалах, шилжүүлэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах, удирдах үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байна. Түүнчлэн ҮЦТХТ нь үнэт цаасны шилжилт хөдөлгөөнийг биет хөдөлгөөнгүйгээр болон биет бус хэлбэрээр хийдэг байх.

Гол асуудал 1. ҮЦТХТ нь үнэт цаас гаргагч болон эзэмшигчийн эрхийг хамгаалах, үнэт цаасыг зөвшөөрөлгүйгээр хэвлэх, бүртгэлээс хасахаас сэргийлэх, хадгалж буй үнэт цаасандаа тохируулга тогтмол (хамгийн багадаа өдөр тутам) хийх зэрэг үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам, хяналт, нягтлан бодох бүртгэлийн найдвартай системтэй байх.

Үнэт цаас гаргагч болон эзэмшигчийн эрхийг хамгаалах

11.1.1 ҮЦТХТ-ийн дүрэм, журам, хяналтын хүрээнд үнэт цаас гаргагч болон эзэмшигчийн эрхийг хэрхэн хамгаалсан бэ?

11.1.2 ҮЦТХТ нь оролцогчийн байршуулсан үнэт цаасыг данс бүртгэлдээ зохих ёсоор тусгаж, үзүүлж буй өөр бусад үйлчилгээтэй холбоотой эрсдэлээс хамгаалах бололцоог дүрэм, журам, хяналтын хүрээнд хэрхэн бүрдүүлсэн бэ?

11.1.3 ҮЦТХТ нь нягтлан бодох бүртгэлийн найдвартай байдлыг хэрхэн хангадаг вэ? Үнэт цаас эзэмшигчийн эрхийг хангагдахуйц хангалттай хэмжээний үнэт цаас байгаа эсэхийг аудитаар хэрхэн үнэлдэг вэ? Үнэт цаасыг хадгалж, хамгаалахад мөрдөж буй дүрэм, журам, дотоод хяналтын үйл ажиллагаанд аудитын үнэлгээ шалгалтыг хэр зэрэг тогтмол хийдэг вэ?

Үнэт цаасыг зөвшөөрөлгүйгээр хэвлэх, бүртгэлээс хасах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх

11.1.4 ҮЦТХТ нь үнэт цаасыг хэвлэх, бүртгэлээс хасах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох ямар дотоод дүрэм, журамтай вэ? ҮЦТХТ нь үнэт цаасыг зөвшөөрөлгүйгээр хэвлэх, бүртгэлээс хасах үйл ажиллагаанаас сэргийлсэн дотоод хяналтын ямар механизмтай вэ?

Үнэт цаасны тохируулгыг тогтмол хийх

11.1.5 ҮЦТХТ нь бүртгэлтэй нийт үнэт цаасыг гаргагч бүрээр нь хамгийн багадаа өдөр бүр тогтмол тохируулдаг уу? Үнэт цаас гаргах бүрт бүртгэгдсэн үнэт цаасны нийт тоо нь ҮЦТХТ-ийн данс бүртгэлд тусгагдсан тухайн үнэт цаасны тоо хэмжээтэй тэнцүү байгаа эсэхийг хэрхэн хянадаг вэ?

11.1.6 Хэрэв ҮЦТХТ нь данс бүртгэлдээ тусгагдсан тухайн үнэт цаасны албан ёсны бүртгэгч биш тохиолдолд албан ёсны бүртгэлтэй нь хэрхэн тохируулга хийдэг вэ?

Гол асуудал 2. ҮЦТХТ нь үнэт цаасны дансыг зээлийн эрхтэй, өрийн үлдэгдэлтэй байхыг хориглох.

11.2.1 ҮЦТХТ нь үнэт цаасны дансыг зээлийн эрхтэй, өрийн үлдэгдэлтэй байхаас хэрхэн сэргийлдэг вэ?

Гол асуудал 3. ҮЦТХТ нь үнэт цаасыг эргэлтэд оруулахгүйгээр (биет хөдөлгөөнгүй болгох) буюу биет бус хэлбэрээр шилжүүлэн нягтлан бодох бүртгэлд тусгадаг байх. Боломжтой бол ҮЦТХТ нь үнэт цаасыг эргэлтэд оруулахгүй байх, биет бус хэлбэрээр гаргахыг дэмжих.

11.3.1 Үнэт цаасыг биет бус хэлбэрээр гаргаж, хадгалдаг уу? Нийт үнэт цаасны хэдэн хувь нь биет бус хэлбэрээр байршиж, нийт гүйлгээний хэдэн хувь нь тэдгээр үнэт цаастай холбоотойгоор хийгдэж байна бэ?

11.3.2 Хэрэв үнэт цаасыг биет гэрчилгээ хэлбэрээр гаргасан бол тэдгээрийг эргэлтэд оруулалгүй, данс бүртгэлийн систем ашиглан бүртгэж, шилжилт хөдөлгөөнийг нь хийх боломжтой юу? Нийт үнэт цаасны хэдэн хувийг эргэлтэд оруулалгүй байлгаж, нийт гүйлгээний хэдэн хувь нь тэдгээр үнэт цаастай холбоотойгоор хийгдэж байна вэ?

11.3.3 ҮЦТХТ нь үнэт цаасыг эргэлтэд оруулалгүй хадгалах, биет бусаар гаргах үйл ажиллагааг хэрхэн дэмждэг вэ?

Гол асуудал 4. ҮЦТХТ нь хууль, эрх зүйн орчинд нийцсэн холбогдох дүрэм, журмаар хөрөнгийг кастодианы эрсдэлээс хамгаалах.

11.4.1 ҮЦТХТ нь кастодианы эрсдэл болон үйл ажиллагааны болгоомжгүй байдлын, хөрөнгийн зүй бус хэрэглээний, залилан луйврын, сул удирдлага зохион байгуулалтын, тайлан бүртгэлийн алдаа, дутагдал зэргээс үүсэх хохирол алдагдлаас оролцогчийн хөрөнгийг дүрэм, журмаараа хэрхэн хамгаалдаг вэ?

11.4.2 ҮЦТХТ нь тэдгээр дүрэм, журмаа хууль, эрх зүйн орчинтой нийцэж буйг хэрхэн тодорхойлдог вэ?

11.4.3 ҮЦТХТ нь оролцогчийг үнэт цаасны шамшигдал, устгал, хулгай зэргээс хамгаалах өөр ямар арга хэрэгсэл ашигладаг вэ? Жишээлбэл, нөхөн төлбөрийн даатгал хийлгэх.

Гол асуудал 5. ҮЦТХТ нь өөрийн хөрөнгийг оролцогчийн үнэт цааснаас, тухайн оролцогчийн үнэт цаасыг бусад оролцогчийн үнэт цааснаас тусгаарлан бүртгэх найдвартай системтэй байх. Түүнчлэн, хууль, эрх зүйн талаас хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд ҮЦТХТ нь оролцогчийн данс бүртгэл дэх харилцагчийн үнэт цаасыг

тусгаарлан бүртгэхийг үйл ажиллагааны зүгээс дэмжих, харилцагчийн үнэт цаасыг шилжүүлэх ажиллагааг хялбарчлах.

11.5.1 ҮЦТХТ нь үнэт цаасыг тусгаарлах, бүртгэх ямар зохицуулалттай вэ? ҮЦТХТ нь өөрийн хөрөнгийг оролцогчийн үнэт цааснаас хэрхэн тусгаарлан бүртгэдэг вэ? ҮЦТХТ нь оролцогчийн үнэт цаасыг бусад оролцогчийн үнэт цааснаас хэрхэн тусгаарлан бүртгэдэг вэ?

11.5.2 Хууль, эрх зүйн талаас хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд ҮЦТХТ нь оролцогчийн данс бүртгэлээс түүний харилцагчдын үнэт цаасыг тусад нь бүртгэх үйл ажиллагааг хэрхэн дэмждэг вэ? Тэдгээр харилцагчийн данснаас өөр оролцогч руу шилжүүлэх ажиллагааг хэрхэн хялбарчилсан бэ?

Гол асуудал 6. ҮЦТХТ-ийн бусад үйл ажиллагаанаас учирч болзошгүй эрсдэлийг тогтоох, үнэлэх, хянах, удирдах шаардлагатай бөгөөд тэдгээрийг тодорхойлохын тулд нэмэлт арга хэрэгслийг ашиглаж болно.

11.6.1 ҮЦТХТ нь үнэт цаасыг төвлөрүүлэн хадгалж, хамгаалах, түүний төлбөр тооцоог хийхээс өөр үйлчилгээ үзүүлдэг үү? Хэрэв тийм бол ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

11.6.2 Хэрэв ҮЦТХТ нь үнэт цаасыг төвлөрүүлэн хадгалж, хамгаалах, түүний төлбөр тооцоог хийхээс өөр үйлчилгээ үзүүлдэг бол тэдгээр үйлчилгээтэй холбоотой зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг хэрхэн тогтоодог вэ?

ЗАРЧИМ 12. Хөрөнгийн дүнгээр солилцох (Exchange-of-value) төлбөр тооцооны систем

Дэд бүтэц нь санхүүгийн хоёр талт үүрэг хариуцлагатай холбогдсон гүйлгээ (жишээлбэл, үнэт цаас, гадаад валютын арилжааны гүйлгээ)-г боловсруулдаг бол холбогдох гүйлгээний төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд л тухайн гүйлгээний төлбөр тооцоог хийж үндсэн эрсдэлээс зайлсхийх шаардлагатай.

Гол асуудал 1. Хөрөнгийн дүнгээр солилцох төлбөр тооцооны систем бүхий дэд бүтцийн хувьд гүйлгээг нэг бүрчлэн эсхүл нэгтгэн боловсруулдаг эсэхээс үл хамааран холбогдох гүйлгээний төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд л тухайн гүйлгээний төлбөр тооцоог хийж үндсэн эрсдэлээс зайлсхийх.

12.1.1 Хууль эрх зүй, гэрээ хэлэлцээр, техник, технологи болон эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо холбогдох санхүүгийн хэрэгслүүдээр хийх гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэснээр үндсэн эрсдэлээс зайлсхийх нөхцөлийг хэрхэн хангаж өгсөн бэ? Холбогдох гүйлгээний төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд л тухайн гүйлгээний төлбөр тооцоог хийх нөхцөлийг ямар журмаар хангаж өгсөн бэ?

12.1.2 Санхүүгийн хоёр талт үүрэг хариуцлагатай холбогдсон гүйлгээний төлбөр тооцоог хэрхэн хийдэг вэ? (арилжаа нэг бүрээр нэг бүрчлэн эсхүл нэгтгэн)

12.1.3 Санхүүгийн хоёр талт үүрэг хариуцлагатай холбогдсон гүйлгээний төлбөр тооцоог нэгэн зэрэг эцэслэн хийдэг үү? Хэрэв үгүй бол тэдгээр гүйлгээний төлбөр тооцоо хэзээ эцсийн болдог вэ? Тэдгээр гүйлгээг тусгаарлахаас эхлэн төлбөрт тооцоог нь гүйцэтгэх хүртэлх хугацааг аль болох багасгаж өгсөн үү? Тухайн тусгаарлагдсан гүйлгээтэй холбоотой хөрөнгийг гуравдагч талын нэхэмжлэлээс хамгаалдаг уу?

12.1.4 АКТ-ийн хувьд бусад дэд бүтэц (ҮЦТТС болон төлбөрийн систем зэрэг)-ийн үзүүлдэг төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP), эсхүл төлбөрийн эсрэг төлбөр (PvP) зарчимд үндэслэсэн үйлчилгээг ашигладаг үү? Хэрэв тийм бол ийм үйлчилгээний найдвартай байдлын түвшинг хэрхэн тодорхойлдог вэ? Холбогдох гүйлгээний төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд л тухайн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх үүднээс ҮЦТТС болон төлбөрийн систем бүхий дэд бүтцүүдтэй гэрээний ямар харилцаа тогтоогоод байна вэ?

Зарчим 13. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дагаж мөрдөх дүрэм, журам

Дэд бүтэц нь оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүсэх нөхцөл байдлыг зохицуулах тодорхой дүрэм, журамтай байна. Эдгээр дүрэм, журам нь хохирол алдагдлыг хязгаарлаж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд орохоос зайлсхийсэн цагаа олсон арга хэмжээг авах, хүлээсэн үүргээ цаашид биелүүлэх бололцоог тухайн системд олгоход чиглэгдсэн байна.

Гол асуудал 1. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд ч дэд бүтэц нь хүлээсэн үүргээ биелүүлсээр байх боломжийг олгох, мөн тухайн нөхцөл байдлын улмаас санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх дүрэм, журамтай байх.

Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дагаж мөрдөх дүрэм, журам

13.1.1 Оролцогчийг ямар нөхцөлд үүргээ (санхүүгийн болон үйл ажиллагааны) биелүүлэх боломжгүй болсон гэж үзэх, мөн тухайн нөхцөл үүссэн байна гэдгийг нь тогтоох арга хэрэгслийн талаар дүрэм, журамдаа сайтар тодорхойлж өгсөн үү? Хэрхэн тогтоодог вэ?

13.1.2 Дүрэм, журмынхаа хүрээнд үүргээ биелүүлэх боломжгүй болсон оролцогчтой холбогдсон дараах асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

1. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй нь тодорхой болсон үед авах арга хэмжээ;
2. Тэдгээр арга хэмжээ нь хэр зэрэг автоматчилагдсан эсхүл гар ажиллагаатай болох;
3. Төлбөр тооцоог хийхтэй холбогдон гарах өөрчлөлт;
4. Гүйлгээ боловсруулах үе шатуудын зохион байгуулалт;
5. Эзэмшигч болон харилцагчийн данс, гүйлгээтэй холбогдуулан авах арга хэмжээ;
6. Холбогдох арга хэмжээг авах дараалал;
7. Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж буй оролцогч зэрэг бусад талуудын үүрэг хариуцлага;
8. Үүдэн гарах үр дагаврыг хязгаарлах үүднээс ашиглаж болох бусад механизм.

Санхүүгийн эх үүсвэрийн ашиглалт

13.1.3 Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсноос үүссэн хохирол алдагдлыг хаах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын дарамтыг хязгаарлах зорилгоор хадгалж буй санхүүгийн эх үүсвэрийг нэн даруй ашиглах бололцоог дүрэм, журамдаа хэрхэн зохицуулсан бэ?

13.1.4 Санхүүгийн эх үүсвэрийг ашиглахтай холбогдсон асуудлыг дүрэм, журамдаа хэрхэн шийдвэрлэсэн вэ?

13.1.5 Тухайн нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх асуудлыг дүрэм, журамдаа хэрхэн шийдвэрлэсэн вэ?

Гол асуудал 2. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дагаж мөрдөх дүрэм, журмыг хэрэгжүүлэх, тэдгээрт тусгагдсан шаардлагатай арга хэмжээг авах зохих бэлтгэлтэй байх.

13.2.1 Үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэхтэй холбогдсон үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан ямар дотоод төлөвлөгөө байна вэ?

13.2.2 Холбогдох эрх бүхий этгээд, хянан шалгагчтай цаг тухайд нь холбоо барих харилцаа холбооны ямар хэлбэрүүд байна вэ?

13.2.3 Үүдэн гарах асуудлыг шийдвэрлэх дотоод төлөвлөгөөг хэр тогтмол үнэлж хянадаг вэ? Энэ төлөвлөгөөтэй холбоотой удирдлага зохион байгуулалтын ямар зохицуулалт байна вэ?

Гол асуудал 3. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед дагаж мөрдөх дүрэм, журмынхаа гол үзэл санааг олон нийтэд ил тод болгох.

13.3.1 Тэдгээр дүрэм, журмын үзэл санааг олон нийтэд хэрхэн ил тод болгодог вэ? Дараах асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

1. Арга хэмжээ авах нөхцөл байдал;
2. Тэдгээр арга хэмжээг хэн авч хэрэгжүүлэх;
3. Эзэмшигч болон харилцагчийн аль алины позиц, хөрөнгө болон активын зохицуулалт зэрэг авах арга хэмжээний цар хүрээ;
4. Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж буй оролцогчидтой холбоотой үүрэг хариуцлагын механизм;
5. Оролцогчдынхоо харилцагчидтай шууд харилцаа холбоотой бол үүргээ биелүүлэх боломжгүй болсон оролцогчийн харилцагчдын өмнө хүлээсэн үүргийг биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх механизм байна уу?

Гол асуудал 4. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болох үед хөрөнгө, позицийг нь худалдан борлуулах зэрэг авах арга хэмжээг үр ашигтай, бодитой байлгах үүднээс туршиж, үнэлэхэд оролцогчид, бусад холбогдох этгээдийг татан оролцуулах. Ийм туршилт, үнэлгээг хамгийн багадаа жил тутам буюу дүрэм, журамдаа томоохон өөрчлөлт оруулах бүрт хийж байх.

13.4.1 Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед авах арга хэмжээг туршиж, үнэлэхэд оролцогчид болон бусад холбогдох этгээдийг хэрхэн татан оролцуулдаг вэ? Ийм туршилт, үнэлгээг хэр тогтмол хийж, үр дүнг нь хэрхэн ашигладаг вэ? Түүнчлэн, захирлуудын зөвлөл, эрсдэлийн удирдлагын хороо болон холбогдох эрх бүхий байгууллагуудад тухайн туршилт, үнэлгээний үр дүнгийн талаар хэр мэдээлдэг вэ?

13.4.2 Туршилт нь оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй түвшинд хүрч болзошгүй ямар нөхцөл байдал, арга хэмжээг хамардаг вэ? Оролцогчдынхоо шийдвэрийг хэрэгжүүлж буй байдлыг хэр үнэлдэг вэ?

Зарчим 14. Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх

АКТ нь оролцогчийнхоо харилцагч этгээдийн позиц, түүнтэй холбогдуулан байршуулсан барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байна.

Гол асуудал 1. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон эсвэл дампуурсан үед түүний харилцагчийн позиц болон барьцаа хөрөнгийг найдвартай хамгаалахын тулд АКТ нь наад зах нь хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх зохицуулалттай байх. Түүнчлэн, АКТ нь оролцогч болон бусад харилцагч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед тухайн харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг хамгаалахтай холбоотой нэмэлт үйлчилгээ үзүүлдэг бол энэхүү үйлчилгээг үр дүнтэй байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх.

Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед харилцагчийг хамгаалах

14.1.1 Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон эсвэл дампуурсан үед АКТ нь тухайн оролцогчийн харилцагчийн байршуулсан позиц, барьцаа хөрөнгийг найдвартай хамгаалахын тулд хөрөнгийн бүртгэлийг тусгаарлан хөтлөх ямар зохицуулалттай вэ?

14.1.2 АКТ нь хөрөнгийг шилжүүлэхтэй холбогдсон ямар зохицуулалттай вэ?

14.1.3 Хэрэв АКТ нь мөнгөний зах зээл дээр үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хөрөнгийн бүртгэлийг тусгаарлан хөтлөх зохицуулалт байхгүй бол харилцагчийн хөрөнгийг хэрхэн хамгаалдаг вэ? АКТ нь харилцагчийн хөрөнгийг хамгаалахдаа бүртгэлийг нь тусгаарлан хөтлөх болон шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт хийж болох ч холбогдох хууль, эрх зүйн хүрээнд тухайн хөрөнгө найдвартай хамгаалагдсан эсэхийг хэрхэн үнэлдэг вэ?

Оролцогч болон бусад харилцагч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед харилцагчийг хамгаалах

14.1.4 АКТ нь оролцогч болон бусад харилцагч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед тухайн харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг хамгаалахтай холбоотой нэмэлт үйлчилгээ үзүүлдэг бол энэ үйлчилгээг хэрхэн үр дүнтэй үзүүлдэг вэ?

Хууль, эрх зүйн үндэслэл

14.1.5 Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг хамгаалах, шилжүүлэхтэй холбоотой АКТ-ийн зохицуулалт нь хууль, эрх зүйн талаас сайтар үндэслэлтэй болохыг хэрхэн баталгаажуулах вэ?

14.1.6 Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтаа үр дүнтэй хэрэгжүүлэх, бусад улс орон дахь болон алслагдмал оролцогчийн талаар АКТ нь ямар шинжилгээ судалгаа хийдэг вэ? Тухайлбал, харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх АКТ-ийн чадавх нь тухайн улс орны ямар хууль тогтоомжтой холбоотой байна вэ? Тогтоогдсон асуудлыг хэрхэн шийдвэрлээд байна вэ?

Гол асуудал 2. АКТ нь харилцагчийн позицийг тодорхойлох, холбогдох барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх ажиллагааг хялбарчилсан бүртгэлийн системийг ашиглах. АКТ нь харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг харилцагч тус бүрийн эсвэл төвлөрсөн дансанд байршуулах.

14.2.1 АКТ нь тухайн харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг бусад оролцогчийн позиц, барьцаа хөрөнгөөс хэрхэн тусгаарладаг вэ? Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг

бүртгэхдээ АКТ нь бүртгэлийн ямар систем (харилцагч бүрийн эсвэл төвлөрсөн дансанд бүртгэх) ашигладаг вэ? Системийн сонголтыг юунд үндэслэн хийдэг вэ?

14.2.2 Хэрэв АКТ нь харилцагчийн позицтой холбогдуулан барьцаа хөрөнгө байршуулдаг бол энэ барьцаа хөрөнгийг юунд ашигладаг вэ? Жишээлбэл, маржины анхны болон хэлбэлзлийн шаардлагыг хангах.

14.2.3 АКТ нь харилцагч бүрийн хүүгийн хэмжээг тодорхойлох зорилгоор тэдний дансны мэдээллийг багтаасан оролцогчийн бүртгэлийг ашигладаг уу? Хэрэв тийм бол АКТ нь дансны энэхүү мэдээлэлд хэрхэн ханддаг вэ?

Гол асуудал 3. АКТ нь оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед түүний харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг бусад оролцогчид шилжүүлэх магадлал хамгийн өндөртэй байхаар хөрөнгө шилжүүлгийн зохицуулалтыг хийх

14.3.1 АКТ нь хөрөнгө шилжүүлгийн зохицуулалтаараа оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед түүний харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг бусад оролцогчид шилжүүлэх ажиллагааг хэрхэн хөнгөвчилж өгсөн бэ?

14.3.2 АКТ нь харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг шилжүүлэхдээ хөрөнгө шилжин очиж буй оролцогчийн зөвшөөрлийг хэрхэн авдаг вэ? Энэхүү зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт АКТ-ийн дүрэм, журамд тусгагдсан уу? Хэрэв тийм бол энэ талаар тайлбарлана уу? Хэрэв дүрэм, журмын хүрээнд тийм зохицуулалт хийгдээгүй бол энэ талаарх мэдээллийг хэрхэн ил тод болгосон бэ?

Гол асуудал 4. АКТ нь харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх ажиллагааг зохицуулсан бодлого, дүрэм, журмаа нийтэд ил тод болгох. Тухайлбал, АКТ нь барьцаа хөрөнгийг харилцагч бүрийн эсвэл төвлөрсөн дансанд байршуулсан эсэхийг мэдэгдэх. Түүнчлэн, АКТ нь харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэхэд тулгарч болзошгүй хууль, эрх зүй, үйл ажиллагааны аливаа хязгаарлалтын талаар мэдээлэх.

14.4.1 АКТ нь харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтаа хэрхэн ил тод болгодог вэ? Энэ нь барьцаа хөрөнгийг харилцагч бүрийн эсвэл төвлөрсөн дансанд тусгасан эсэх талаарх мэдээлэл багтаасан байдаг уу?

14.4.2 Харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэх ажиллагаатай холбоотой эрсдэл, зардал, бусад тодорхой бус зүйлсийн талаар АКТ нь хэрхэн тодорхойлж, хаана мэдээлдэг вэ? АКТ нь харилцагчийн позиц, барьцаа хөрөнгийг тусгаарлан бүртгэх, шилжүүлэхэд тулгарч болзошгүй хууль, эрх зүйн болон үйл ажиллагааны аливаа хязгаарлалтын талаар хэрхэн мэдээлдэг вэ?

Зарчим 15. Бизнесийн эрсдэл

Дэд бүтэц нь бизнесийн эрсдэлээ тодорхойлж, хянаж, удирдаж, томоохон алдагдал хүлээсэн тохиолдолд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, үйлчилгээгээ үзүүлсээр байхын тулд өөрийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх хангалттай, цэвэр хөрөнгөтэй байна. Түүнчлэн, түргэн хөрвөх цэвэр хөрөнгө нь голлох үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой саатал гарсан зэрэг системийг сэргээн засварлаж, үйлчилгээгээ хэвийн үзүүлэхэд ямар ч үед хүрэлцэхүйц байх.

Гол асуудал 1. Бизнесийн стратеги төлөвлөлтийн тааруухан гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн гадагшлах урсгал, үйл ажиллагааны гэнэтийн томоохон зардал зэргээс үүдэлтэй хохирол алдагдал, бизнесийн эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдах хяналтын болон удирдлагын найдвартай тогтолцоотой байх.

15.1.1 Бизнесийн эрсдэлээ хэрхэн тодорхойлдог вэ? Одоогоор бизнесийн ямар эрсдэлүүд байна вэ?

15.1.2 Бизнесийн эрсдэлээ хэрхэн тогтмол хянаж, удирддаг вэ?

Гол асуудал 2. Хохирол алдагдал хүлээсэн ч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулан, үйлчилгээ үзүүлэхийн тулд энгийн хувьцаа, нөөц сан, хуримтлагдсан ашиг зэрэг өөрийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх цэвэр хөрөнгөтэй байх. Өөрийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх цэвэр хөрөнгийн хэмжээг тогтооход бизнесийн эрсдэлийн түвшин болон үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбогдон гарсан саатлыг засварлах, системийн ачааллыг шат дараалалтайгаар бууруулахад шаардагдах хугацааг үндэслэнэ.

15.2.1 Хохирол алдагдал хүлээсэн ч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулан үйлчилгээ үзүүлэхийн тулд өмчийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх цэвэр хөрөнгийг байршуулдаг уу?

15.2.2 Бизнесийн эрсдэлд өртөхөөс хамгаалах зорилгоор өөрийн хөрөнгөөр бүрдүүлэх түргэн хөрвөх цэвэр хөрөнгийн хэмжээг хэрхэн тооцоолдог вэ? Үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбогдон гарсан саатлыг засварлаж, системийн ачааллыг шат дараалалтайгаар бууруулахад шаардагдах хугацааг хэрхэн тогтоодог вэ?

Гол асуудал 3. Засвар үйлчилгээг үр дүнтэй хийх, ачааллыг шат дараалалтайгаар бууруулах, хэрэгжүүлж болохуйц төлөвлөгөөтэй байх ба энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах өөрийн хөрөнгөөс бүрдсэн, түргэн хөрвөх хангалттай цэвэр хөрөнгөтэй байх. Хамгийн багадаа 6 сарын үйл ажиллагааны урсгал зардалтай тэнцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөөс бүрдүүлсэн түргэн хөрвөх цэвэр хөрөнгөтэй байх нь зүйтэй. Түүнчлэн, санхүүгийн эх үүсвэрийн зарчмуудын дагуу энэхүү хөрөнгө нь оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон үеийн болон бусад хүчин зүйлсээс үүдэлтэй эрсдэлээс хамгаалах эх үүсвэр болно. Гэхдээ эрсдэлд суурилсан хөрөнгийн удирдлагын олон улсын стандартын дагуу энэхүү өөрийн хөрөнгөө хөрөнгийн давхардсан шаардлагуудаас зайлсхийхэд тохиромжтой хэлбэрээр байршуулах боломжтой.

Засвар үйлчилгээ хийх, ачааллыг шат дараалалтайгаар бууруулах төлөвлөгөө

15.3.1 Засвар үйлчилгээ хийх, ачааллыг шат дараалалтай бууруулах төлөвлөгөөг зохих ёсоор боловсруулсан уу? Хэрэв тийм бол уг төлөвлөгөө нь юунд анхаарал хандуулсан бэ? Жишээ нь, зохион байгуулалтын боломжит хувилбаруудыг бий болгох, тэдгээрт шилжихтэй холбогдон оролцогчдод тавигдах үйл ажиллагаа, технологи болон хууль, эрх зүйн шаардлагуудад онцгойлон анхаарах гэх мэт.

Нөөц бололцоо

15.3.2 Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх хэдий хэмжээний цэвэр хөрөнгө байршуулаад байна вэ? Тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд байршуулсан хөрөнгө хангалттай эсэхийг хэрхэн тодорхойлдог вэ? Хамгийн

багадаа 6 сарын үйл ажиллагааны урсгал зардалтай тэнцэхүйц хэмжээний хөрөнгө байж чадах уу?

15.3.3 Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас болон бусад хүчин зүйлсээс үүдэлтэй эрсдэлээс хамгаалах зорилгоор санхүүгийн эх үүсвэрийн зарчмуудын дагуу байршуулсан эх үүсвэрээс бизнесийн болзошгүй эрсдэл, хохирол алдагдлыг даван туулахад зориулсан эх үүсвэрийг хэрхэн тусгаарладаг вэ?

15.3.4 Бизнесийн эрсдэлээс хамгаалах зорилгоор эрсдэлд суурилсан хөрөнгийн удирдлагын олон улсын стандартын дагуу байршуулсан өмчийн хөрөнгөтэй юу?

Гол асуудал 4. Зах зээлийн нөхцөл байдал таагүй болох зэрэг янз бүрийн нөхцөлд үйл ажиллагааны урсгал болон төлөвлөгөөт зардлаа санхүүжүүлэхийн тулд бизнесийн эрсдэлээс хамгаалах зорилгоор бүрдүүлж буй хөрөнгөө чанартай, түргэн хөрвөх хөрөнгөөр бүрдүүлэх.

15.4.1 Өөрийн хөрөнгөөс бүрдсэн түргэн хөрвөх цэвэр хөрөнгөө ямар хөрөнгөөр бүрдүүлсэн бэ? Зах зээлийн нөхцөл байдал таагүй болсон эсхүл шаардлагатай тохиолдолд тэдгээр хөрөнгийг үнэ цэнийн алдагдалгүйгээр эсхүл багахан алдагдалтайгаар мөнгөн хөрөнгөд хэрхэн хөрвүүлэх вэ?

15.4.2 Зах зээлийн нөхцөл байдал таагүй болох зэрэг янз бүрийн нөхцөлд үйл ажиллагааны урсгал болон төлөвлөгөөт зардлаа санхүүжүүлэхийн тулд өөрийн хөрөнгөөр бүрдүүлсэн түргэн хөрвөх цэвэр хөрөнгийн чанар, хөрвөх чадварыг хэр тогтмол үнэлдэг вэ?

Гол асуудал 5. Өмчийн хөрөнгө нь тогтоосон доод хэмжээнд хүртэл эсхүл тухайн хэмжээнд хүрэхгүй болтлоо багассан үед нэмэлт хөрөнгө босгох оновчтой төлөвлөгөөтэй байх. Энэхүү төлөвлөгөөг захирлуудын зөвлөлөөр батлуулж, тогтмол шинэчилж байх.

15.5.1 Нэмэлт хөрөнгө бий болгох төлөвлөгөө боловсруулсан эсэх? Өөрийн хөрөнгө нь тогтоосон доод хэмжээнд хүртэл эсхүл тухайн хэмжээнд хүрэхгүй болтол багассан үед нэмэлт хөрөнгө бий болгох төлөвлөгөөнийхөө гол онцлогийг хэрхэн харж байна вэ?

15.5.2 Энэхүү төлөвлөгөөг хэр зэрэг тогтмол үнэлж хянан, шинэчилдэг вэ?

15.5.3 Энэхүү нэмэлт хөрөнгө бий болгох төлөвлөгөөг үнэлж хянах, батлахад захирлуудын зөвлөл ямар үүрэгтэй вэ?

ЗАРЧИМ 16: Кастодианы үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын эрсдэлүүд

Дэд бүтэц нь өөрийн болон оролцогчдынхоо хөрөнгийг найдвартай хамгаалж, тэдгээрийг удирдахад хугацаа алдсанаас үүсэх эрсдэлийг бууруулна. Дэд бүтэц нь зээлийн, зах зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл хамгийн багатай хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй.

Гол асуудал 1. Өөрийн болон оролцогчдынхоо хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн найдвартай систем, хадгалалт, хамгаалалтын дүрэм, журам, дотоод хяналтын тогтолцоотой, эрх бүхий байгууллагын хяналт шалгалт, зохицуулалтад хамрагддаг хуулийн этгээдэд хадгалуулах.

16.1.1. Дэд бүтэц нь кастодианы үйлчилгээ ашигладаг бол тэдгээр кастодианыг хэрхэн сонгодог вэ? Хяналт шалгалт, зохицуулалтад хамрагдах байдлаас гадна сонгон шалгаруулалтын ямар шалгуур ашигладаг вэ? Кастодианы шаардлага, шалгуурыг хангаж буй байдалд нь хэрхэн хяналт тавьдаг вэ?

16.1.2. Тухайн байгууллага нь хөрөнгийг найдвартай хадгалж, хамгаалж чадахуйц нягтлан бодох бүртгэл систем, хадгалалт, хамгаалалтын журам, дотоод хяналттай эсэхийг нь хэрхэн магадлан шалгадаг вэ?

Гол асуудал 2. Шаардлагатай тохиолдолд өөрийн болон оролцогчдынхоо хөрөнгийг шуурхай удирдах боломжтой байх.

16.2.1. Кастодианд хадгалагдаж буй хөрөнгийн эзэмшил болон түүнтэй холбогдох эрх ашиг, сонирхлыг хамгаалах хууль, эрх зүйн найдвартай үндэслэлийг хэрхэн бүрдүүлсэн вэ?

16.2.2. Оролцогч үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд өөр цагийн бүс эсхүл нутаг дэвсгэр дэх кастодианд хадгалагдаж буй үнэт цаас зэрэг хөрөнгийг шуурхай удирдах бололцоог хэрхэн бүрдүүлсэн бэ?

Гол асуудал 3. Кастодиан банкуудтай тогтоосон бизнесийн харилцаа холбооныхоо цар хүрээг харгалзан тэдний үйл ажиллагаанд учруулж болзошгүй эрсдэлээ үнэлж, тодорхойлох.

16.3.1. Кастодиан банкуудад учруулж болзошгүй эрсдэлээ хэрхэн үнэлж, тодорхойлдог вэ? Тэдгээр эрсдэлийг удирдахдаа кастодиан банк бүртэй тогтоосон харилцаа холбооны цар хүрээг хэрхэн харгалзан үздэг вэ? Жишээ нь, эрсдэлийг тараан байршуулах үүднээс хөрөнгөө хэд хэдэн кастодиан банкуудад хадгалуулдаг уу? Кастодиан банкуудад үүсэж буй төвлөрлийн эрсдэлд хэрхэн хяналт тавьдаг вэ?

Гол асуудал 4. Хөрөнгө оруулалтын стратегийг эрсдэлийн удирдлагын стратегитай бүрэн нийцүүлж, оролцогчдод нээлттэй, ил тод болгох. Найдвартай, итгэл хүлээлгэж болохуйц этгээдэд хөрөнгө оруулалт хийж, шаардлагатай тохиолдолд тухайн хөрөнгө оруулалтаар аль болох алдагдалгүй төлбөр барагдуулах боломжтой байх.

Хөрөнгө оруулалтын стратеги

16.4.1. Хөрөнгө оруулалтын стратегийг эрсдэлийн удирдлагын стратегитайгаа бүрэн нийцүүлсэн гэдгийг хэрхэн нягтлан шалгадаг вэ? Хөрөнгө оруулалтын стратегийг хэнд, хэрхэн нээлттэй, ил тод болгодог вэ?

16.4.2. Найвартай, итгэл хүлээлгэж болохуйц этгээдэд хөрөнгө оруулалт хийсэн эсэхийг хэрхэн нягтлан шалгадаг вэ?

Хөрөнгө оруулалтын эрсдэлийн хүчин зүйл

16.4.3. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа санхүүгийн хариуцлага хүлээж буй тухайн этгээдийн эрсдэлийг хэрхэн үнэлж тооцдог вэ? Зээлийн төвлөрлийн эрсдэлээс зайлсхийх үүднээс хөрөнгө оруулалтын ямар хязгаарлалтыг тогтоосон бэ?

16.4.4. Оролцогчдын хөрөнгөөр өөрсдийнх нь болон охин компаниудынх нь үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг үү?

16.4.5. Тухайн хөрөнгө оруулалтаар аль болох алдагдалгүй төлбөр барагдуулах боломжтой эсэхийг хэрхэн нягтлан шалгадаг бэ?

Зарчим 17. Үйл ажиллагааны эрсдэл

Дэд бүтэц нь үйл ажиллагааны эрсдэлийн дотоод, гадаад боломжит хүчин зүйлсийг тодорхойлж, оновчтой бодлого, журам, систем, хяналтын механизмаар дамжуулан тэдгээрийн үр дагаврыг бууруулна. Систем нь аюулгүй байдал, үйл ажиллагааны найдвартай байдлыг өндөр түвшинд хангахаар төлөвлөгдсөн байхын зэрэгцээ ачаалал даан ажиллах хангалттай хүчин чадалтай байна. Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөө нь өргөн хүрээтэй томоохон саатал гарсан үед ч гэсэн тухайн системд үйл ажиллагааг цаг алдалгүй сэргээж, үүргээ биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Гол асуудал 1. Үйл ажиллагааны эрсдэлээ тодорхойлж, хянаж, удирдах оновчтой бодлого, журам, систем, хяналт бүхий үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын найдвартай тогтолцоог бүрдүүлэх.

Үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох нь

17.1.1. Үйл ажиллагааны эрсдэлийн болзошгүй хүчин зүйлсийг тодорхойлох ямар бодлого баримталж, арга хэмжээ авч байна вэ? Ийм арга хэмжээг авснаар үйл ажиллагааны эрсдэлийн болзошгүй хүчин зүйлсийг хэрхэн тогтоож, тухайн эрсдэл нь дотоод (системийн зохион байгуулалт, хүний нөөц зэрэг) эсхүл гадаад хүчин зүйлс (оролцогч гэх мэт)-ээс шалтгаалан бий болж болохыг хэрхэн тодорхойлдог вэ?

17.1.2. Үйл ажиллагааны эрсдэлийн ямар хүчин зүйлсийг олж тогтоогоод байна вэ?

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

17.1.3. Олж тогтоосон үйл ажиллагааны эрсдэлийг хэрхэн хянаж, удирддаг вэ? Тэдгээр бодлого, журам, систем, хяналтын талаар ямар баримт бичигт хэрхэн тусгасан бэ?

Бодлого, арга хэмжээ, хяналт

17.1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж буй журмын зохистой хэрэгжилтийг хангуулахад чиглэгдсэн ямар бодлого, арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлдэг вэ? Бодлого, журам, систем, хяналтын механизмыг үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын талаарх олон улсын, үндэсний, салбарын холбогдох стандартуудтай хэр нийцүүлсэн бэ?

17.1.5. Мэргэшсэн боловсон хүчнийг олж, бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар хүний нөөцийн ямар бодлого баримталдаг вэ? Тэдгээр бодлогыг баримталснаар хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг багасгаж, мэргэшсэн ажилтан, албан хаагчдаа алдах эрсдэлийг хэрхэн бууруулж байна вэ? Хүний нөөцийн болон эрсдэлийн удирдлагын бодлогынхоо хүрээнд залилан, луйврын шинж чанартай үйл ажиллагаанаас хэрхэн урьдчилан сэргийлдэг вэ?

17.1.6. Аливаа шинэчлэлт, өөрчлөлт болон томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үед системийн хэвийн ажиллагаа санамсаргүй байдлаар алдагдах эрсдэлийг шинэчлэлт, өөрчлөлт болон төслийн удирдлагын бодлогоороо хэрхэн бууруулдаг бэ?

Гол асуудал 2. Захирлуудын зөвлөлөөс үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог журамлан баталж, холбогдох албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох. Бодлого, журам, систем, хяналтын механизмыг тогтмол (мөн томоохон шинэчлэлт, өөрчлөлт хийсний дараа) үнэлж, аудитаар баталгаажуулж, туршдаг байх.

Үүрэг, хариуцлага, тогтолцоо

17.2.1. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон голлох албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг захирлуудын зөвлөлөөс хэрхэн тодорхойлсон бэ?

17.2.2. Захирлуудын зөвлөл нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайтар үнэлж дүгнэн, баталдаг уу? Зөвлөл нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог цаг хугацааны ямар давтамжтайгаар үнэлж дүгнэн, баталдаг вэ?

Үнэлгээ, аудит, туршилт

17.2.3. Бодлого, журам, систем, хяналтын механизмаа хэрхэн үнэлдэг вэ? Оролцогчидтойгоо хамтарсан үнэлгээ, аудит, туршилтыг хэр тогтмол хийдэг вэ?

17.2.4. Үйл ажиллагааныхаа эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөндлөнгийн хяналтаар хэр зэрэг баталгаажуулдаг вэ?

Гол асуудал 3. Үйл ажиллагааныхаа найдвартай байдлыг хангах талаар тодорхой зорилтууд дэвшүүлж, тэдгээрт хүрэхэд чиглэсэн бодлого баримтлах.

17.3.1. Үйл ажиллагааныхаа найдвартай байдлыг хангахад чиглэсэн чанарын болон тоон үзүүлэлтээр илэрхийлэгдэх ямар зорилтууд дэвшүүлээд байна вэ? Эдгээрийн талаар ямар баримт бичигт хэрхэн тусгасан вэ?

17.3.2. Тэдгээр зорилт нь үйл ажиллагааны найдвартай байдлыг хэрхэн хангаж байна вэ?

17.3.3. Тэдгээр зорилтод хүрэхэд чиглэсэн болон шаардлагатай тохиолдолд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг тодорхойлсон ямар бодлого баримталж байна вэ?

Гол асуудал 4. Өсөн нэмэгдэж буй ачааллыг даан, зорилтот үйлчилгээгээ үзүүлэх хангалттай хүчин чадалтай байх.

17.4.1. Наад зах нь системийн төлөвлөгөөт ачааллыг давж гарахуйц хангалттай, өсөн нэмэгдүүлэх боломжтой хүчин чадалтай эсэхийг хэрхэн үнэлж, баталгаажуулж, туршдаг вэ? Энэ төрлийн үнэлгээ, баталгаажуулалт, туршилтыг хэр тогтмол хийдэг вэ?

17.4.2. Үйл ажиллагааны хүчин чадлын дээд түвшинд дөхсөн эсхүл хэтэрсэн үед ямар арга хэмжээг авдаг вэ?

Гол асуудал 5. Болзошгүй эмзэг байдал, аюул заналаас урьдчилан сэргийлж, хамгаалах зорилго бүхий мэдээллийн болон орчны аюулгүй байдлын цогц бодлоготой байх.

Орчны аюулгүй байдал

17.5.1. Орчны эмзэг байдал, аюул заналын болзошгүй хүчин зүйлсийг олж тогтоох талаар ямар бодлого баримталж, арга хэмжээ авч байна вэ? (шинэчлэлт, өөрчлөлт болон төслийн удирдлагын бодлого, арга хэмжээ гэх мэт)

17.5.2. Авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, хяналт, туршилт нь орчны аюулгүй байдлын олон улсын, үндэсний, салбарын холбогдох стандартуудтай нийцэж байгаа юу?

Мэдээллийн аюулгүй байдал

17.5.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд аливаа эмзэг байдал, аюул заналын болзошгүй хүчин зүйлсийг олж тогтоох талаар ямар бодлого баримталж, арга хэмжээ авч байна вэ? (шинэчлэлт, өөрчлөлт болон төслийн удирдлагын бодлого, арга хэмжээ гэх мэт)

17.5.4. Авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, хяналт, туршилт нь мэдээллийн аюулгүй байдлын олон улсын, үндэсний, салбарын холбогдох стандартуудтай нийцэж байгаа юу?

Гол асуудал 6. Өргөн хүрээг хамарсан томоохон саатлын шалтгаан зэрэг үйл ажиллагааны сааталд хүргэж болохуйц ноцтой эрсдэл үүссэн тохиолдолд хэрэгжүүлэх бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөтэй байх. Энэхүү төлөвлөгөөнд нөөц төвийн талаар онцгойлон тусгахын зэрэгцээ саатал гарснаас хойш 2 цагийн дотор үндсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон асуудлуудыг тодорхойлсон байх. Түүнчлэн, энэ төлөвлөгөөгөөр онцгой байдал үүссэн байлаа ч саатал гарсан тухайн өдрийн эцэс гэхэд төлбөр тооцоог гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх. Зохицуулалтын эдгээр механизмыг тогтмол туршилт хийж, шалгадаг байх.

Тасралтгүй байдлын төлөвлөгөөний зорилго

17.6.1. Тасралтгүй байдлын төлөвлөгөөндөө өргөн хүрээг хамарсан томоохон саатал гарсны дараа үндсэн системийн хэвийн үйл ажиллагааг цаг алдалгүй сэргээхэд чиглэсэн зорилго, бодлого, журмын талаар хэрхэн тусгасан бэ?

Тасралтгүй байдлын төлөвлөгөөний загвар

17.6.2. Тасралтгүй байдлын төлөвлөгөөндөө саатал гарснаас хойш 2 цагийн дотор үндсэн системийн үйл ажиллагааг сэргээх, онцгой байдал үүссэн байлаа ч тухайн өдрийн эцэс гэхэд төлбөр тооцоог гүйцэтгэх боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн бэ?

17.6.3. Урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүссэн үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд саатал гарсан тухайн мөчид цаг алдалгүй гүйлгээ бүрийн төлвийг тогтоох бололцоог хэр зэрэг бүрдүүлж өгсөн бэ? Хэрвээ гүйлгээний мэдээлэл алдагдах эрсдэл байгаа бол үүнийг шийдвэрлэх ямар зохицуулалт байна вэ? (жишээ нь, оролцогч болон гуравдагч талтай тохируулга хийх гэх мэт)

17.6.4. Хямрал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дотоод, гадаадын томоохон хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудтай үр дүнтэй харилцаа холбоо тогтоох хэрэгцээ шаардлагыг хэрхэн тодорхойлсон бэ?

Нөөц төв

17.6.5. Тасралтгүй байдлын төлөвлөгөөндөө нөөц төвтэй холбоотой асуудал (хангалттай нөөц, бололцоо, хүчин чадал, тоног төхөөрөмж, шаардлагатай боловсон хүчин гэх мэт)-ыг хэрхэн тусгасан бэ? Нөөц төвөө үндсэн төвөөс газар зүйн байршлын хувьд хэр хол газар байгуулсан вэ?

17.6.6. Онцгой байдлын үед яаралтай гүйлгээг боловсруулахтай холбоотой ямар зохицуулалт байна вэ? (жишээ нь, төлбөрийн даалгавар ашиглах)

Үнэлгээ, туршилт

17.6.7. Тасралтгүй байдлын төлөвлөгөө болон урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлэх зохицуулалтуудаа өргөн хүрээтэй томоохон саатлын үед хэр үр дүнтэй байхыг хэрхэн үнэлж, туршдаг вэ? Ийм үнэлгээ, туршилтыг хэр тогтмол хийдэг вэ?

17.6.8. Тасралтгүй байдлын төлөвлөгөө болон урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлэх зохицуулалтуудын үнэлгээ, туршилтад оролцогчид, нэн чухал үйлчилгээ үзүүлэгч, хамтын ажиллагаа бүхий төлбөр тооцооны системийг хэрхэн татан

оролцуулдаг вэ? Ооролцогчид, нэн чухал үйлчилгээ үзүүлэгч, хамтын ажиллагаа бүхий төлбөр тооцооны системийг үнэлгээ, туршилтад хэр тогтмол оролцуулдаг вэ?

Гол асуудал 7. Томоохон оролцогчид, бусад дэд бүтэц, мэдээллийн технологийн болон бусад үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаатай холбоотойгоор учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, хянаж, удирдах. Түүнчлэн, үйл ажиллагаанаас нь үүдэн бусад дэд бүтцэд учруулж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, хянаж, удирдах.

Үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд

17.7.1. Томоохон оролцогчид, бусад төлбөр тооцооны систем, үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотойгоор учирч болзошгүй үйл ажиллагааны ямар эрсдэл байна вэ? Эдгээр эрсдэлийг хэрхэн хянаж, удирддаг вэ?

17.7.2. Хэрэв үйл ажиллагаандаа шууд нөлөөлөхүйц үйлчилгээг аутсорсингийн хэлбэрээр авдаг бол тэдгээр үйлчилгээ үзүүлэгчдийн үзүүлж буй үйлчилгээ нь дотоодод тавигдах шаардлага, шалгуурт нийцэх эсэхийг хэрхэн тогтоодог вэ?

Бусад дэд бүтцэд учруулж болзошгүй эрсдэлүүд

17.7.3. Бусад дэд бүтцийн үйл ажиллагаанд учруулж болзошгүй эрсдэлийг хэрхэн тодорхойлж, хянаж, бууруулдаг вэ?

17.7.4. Тасралтгүй байдлын төлөвлөгөөг бусад дэд бүтцийн төлөвлөгөөтэй хэр зэрэг нийцүүлэн авч үздэг вэ?

Зарчим 18. Оролцогчид тавигдах шаардлага, шалгуур

Дэд бүтэц нь оролцогчдод шударга, нээлттэй оролцоог дэмжсэн, эрсдэлд суурилсан, олон нийтэд ил тод шаардлага, шалгуурыг тавина.

Гол асуудал 1. Эрсдэлд суурилсан зохих шаардлага, шалгуурыг тавих замаар шууд ба шууд бус оролцогчид болон бусад дэд бүтцэд шударга, нээлттэй хэлбэрээр үйлчилгээ авах бололцоо олгох.

Оролцогчдод тавигдах шаардлага, шалгуур

18.1.1. Оролцогчдод үйл ажиллагааны, санхүүгийн, хууль эрх зүйн гэх мэт ямар шаардлага, шалгуур тавьдаг вэ?

18.1.2. Эрсдэлд суурилсан тэдгээр шаардлага, шалгуурыг тогтоосноор шууд ба шууд бус оролцогчид, бусад дэд бүтцэд шударга, нээлттэй зарчмаар үйлчилгээ авах бололцоог хэрхэн бүрдүүлсэн бэ?

АМС-гийн үйлчилгээний нөхцөл

18.1.3. Өрсөлдөөн болон арилжааны дараах боловсруулалттай холбогдсон шинэчлэлт сайжруулалтын асуудлыг үйлчилгээний нөхцөлөөрөө хэрхэн дэмжсэн бэ? Түүнчлэн, бусад дэд бүтэц болон мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай холбогдсон бизнесийн харилцаа холбоог үйлчилгээний нөхцөлөөрөө хэрхэн дэмжиж өгсөн бэ?

Гол асуудал 2. Оролцогчдод тавьж буй шаардлага, шалгуур нь тухайн дэд бүтцийн найдвартай, үр ашигтай байдал, зах зээлд үзүүлж буй үүрэг оролцоо, эрсдэлийн удирдлагатай нь нийцсэн, олон нийтэд нээлттэй, ил тод байх. Эрсдэлийн удирдлагын

хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг дагаж мөрдөж буй дэд бүтцийн хувьд тухайн нөхцөлд үйлчилгээг аль болох хүндрэлгүй үзүүлэхэд чиглэгдсэн шаардлага, шалгуурыг тогтоохыг эрмэлзэх.

Оролцогчдод тавьж буй шаардлага, шалгуурын үндэслэл шалтгаан

18.2.1. Үйл ажиллагааны найдвартай, үр ашигтай байдал, зах зээлд үзүүлж буй үүрэг оролцоо, эрсдэлийн удирдлагын тогтолцоотой уялдуулан оролцогчдод тавьж буй шаардлага, шалгуурыг хэрхэн тайлбарлах вэ?

18.2.2. Эрсдэлд суурилсан аргачлалаар тогтоогоогүй ч холбогдох хууль, журмын дагуу оролцогчдод тавьж буй шаардлага, шалгуур байгаа юу? Хэрэв байгаа бол ямар шаардлага, шалгуур байна вэ?

18.2.3. Бүх оролцогчдод ижил шаардлага, шалгуур тавьдаг уу? Хэрэв үгүй бол ямар үндэслэл шалтгаанаар харилцан адилгүй шаардлага, шалгуур тогтоосон бэ? Жишээ нь, үйл ажиллагааны цар хүрээ, төрөл хэлбэр, гуравдагч талыг төлөөлж буй эсхүл тодорхой эрх бүхий байгууллагын зохицуулалтад хамрагддаггүй оролцогчдод нэмэлт шаардлага тавих.

Үйлчилгээг аль болох хүндрэлгүйгээр үзүүлэх

18.2.4. Тухайн нөхцөл байдалд нийцүүлэн үйлчилгээг аль болох хүндрэлгүйгээр үзүүлэхийн тулд тавьж буй шаардлага, шалгуур, хязгаарлалтуудаа хэрхэн үнэлдэг вэ? Ийм үнэлгээг хэр тогтмол хийдэг вэ?

Шаардлага, шалгуурын ил тод байдал

18.2.5. Оролцогчид тавигдах шаардлага, шалгуур, хязгаарлалтуудыг олон нийтэд хэрхэн ил тод болгодог вэ?

Гол асуудал 3. Оролцогчдод тавьж буй шаардлага, шалгуурын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, тэдгээр шаардлага, шалгуурыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зөрчил, дутагдал гаргасан эсхүл тэдгээрийг хэрэгжүүлэхгүй байгаа оролцогчийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлах талаар тодорхой, ил тод дүрэм, журамтай байх.

Хэрэгжилтэд хяналт тавих

18.3.1. Тавьж буй шаардлага, шалгуураа тогтмол хэрэгжиж буй эсэхэд хэрхэн хяналт тавьдаг вэ? Хэрэгжилтэд хяналт тавихад ашиглаж буй мэдээллийн үнэн зөв байдлыг бодлого, журмынхаа хүрээнд хэрхэн хангаж өгдөг вэ?

18.3.2. Эрсдэлийн түвшин нь нэмэгдэж буй оролцогчид нарийвчилсан хяналт шалгалт хийх, нэмэлт шаардлага тавих талаар ямар бодлого баримталж байна вэ?

Оролцогчийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлах

18.3.3. Тавьж буй шаардлага, шалгуурыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зөрчил, дутагдал гаргасан эсхүл тэдгээрийг хэрэгжүүлэхгүй байгаа оролцогчийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлах талаар ямар журамтай вэ?

18.3.4. Оролцогчийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлахтай холбогдсон журмаа олон нийтэд хэрхэн ил тод, нээлттэй болгодог вэ?

Зарчим 19. Шууд бус оролцогчтой холбогдсон зохицуулалт

Дэд бүтэц нь шууд бус оролцогчидтой холбоотой зохицуулалтаас үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, хянаж, удирдана.

Гол асуудал 1. Шууд бус оролцогчидтой холбоотой зохицуулалтаас үүсэж болзошгүй томоохон эрсдэлүүдийг олж тогтоон, хянаж, удирдах үүднээс тэдгээрийн талаарх ерөнхий мэдээллийг олж авах бололцоог дүрэм, журам, гэрээний түвшинд бүрдүүлэх.

Шууд бус оролцогчидтой холбогдсон зохицуулалтууд

19.1.1. Шууд бус оролцогчидтой холбогдсон зохицуулалт байгаа юу? Хэрэв байгаа бол энэ талаар тайлбарлана уу.

19.1.2. Шууд бус оролцогчдын талаарх ерөнхий мэдээллийг хэрхэн олж авдаг вэ? Ямар мэдээлэл цуглуулж, хэр тогтмол шинэчилдэг вэ?

Болзошгүй эрсдэлүүд

19.1.3. Тэдгээр зохицуулалттай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлийг хэрхэн үнэлдэг вэ?

19.1.4. Шууд бус оролцогчидтой холбогдсон зохицуулалтын хүрээнд үүссэн ямар томоохон эрсдэл байна вэ? Тэдгээрийг хэрхэн бууруулж байна вэ?

Гол асуудал 2. Шууд ба шууд бус оролцогчдын хооронд нийт дэд бүтцийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавар дагуулж мэдэхүйц бизнесийн томоохон хараат байдал үүссэн эсэхийг олж тогтоох.

19.2.1. Нийт дэд бүтцийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавар дагуулж мэдэхүйц бизнесийн томоохон хараат байдал шууд ба шууд бус оролцогчдын хооронд үүссэн эсэхийг хэрхэн олж тогтоодог вэ?

Гол асуудал 3. Дэд бүтцээр дамжиж буй гүйлгээний нэлээд хэсгийг хариуцдаг мөн тухайн шууд оролцогчийн хэмжээнд хийж буй гүйлгээнийх нь тоо, дүн харьцангуй их шууд бус оролцогчдыг тогтоон, улмаар тэдний гүйлгээнээс учирч болзошгүй эрсдэлийг удирдах.

19.3.1. Дараах үзүүлэлтүүдийг тодорхойлсон уу?

- а) Шууд бус оролцогчдыг төлөөлөн хийж буй үйл ажиллагааны тухайн шууд оролцогчийн хүчин чадалтай харьцуулсан үзүүлэлт,
- б) Нэлээд олон тооны шууд бус оролцогчдыг төлөөлж буй шууд оролцогчид,
- в) Боловсруулж буй гүйлгээний нэлээд хэсгийг хариуцаж буй шууд бус оролцогчид,
- г) Гүйлгээтэй нь холбоотой үүсэж болзошгүй эрсдэлийг удирдах зорилгоор шууд оролцогчийнхоо хүчин чадалтай харьцуулахад гүйлгээнийх нь тоо, дүн харьцангуй их шууд бус оролцогчдыг олж тогтоосон уу?

19.3.2. Томоохон шууд бус оролцогчдын зүгээс ямар эрсдэл учруулж болох вэ? Тэдгээрийг хэрхэн удирдаж байна вэ?

Гол асуудал 4. Шууд бус оролцогчидтой холбоотой зохицуулалтаас үүсэж болзошгүй эрсдэлийг тогтмол үнэлж, зохимжтой бууруулах арга хэмжээг авах.

19.4.1. Шууд бус оролцогчидтой холбоотой зохицуулалтаас үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулахын тулд дүрэм, журмаа үнэлэх талаар ямар бодлого баримталдаг вэ? Ийм үнэлгээг хэр тогтмол хийдэг вэ?

19.4.2. Холбогдох эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэзээ авч хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлох ямар шалгуур байна вэ? Эрсдэлээ хэрхэн хянаж, бууруулдаг вэ?

Зарчим 20. Дэд бүтцийн хамтын ажиллагаа

Бусад дэд бүтэцтэй хамтын ажиллагаа бүхий дэд бүтэц нь хамтын ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдана.

Гол асуудал 1. Дэд бүтэц нь хамтын ажиллагаа тогтоохын өмнө болон тогтоосноос хойш хамтын ажиллагаатай холбоотой эрсдэлийн болзошгүй хүчин зүйлсийг тогтмол тодорхойлж, хянаж, удирдаж байх. Түүнчлэн, дэд бүтэц бүр нь энэхүү тайлан дахь бусад зарчмыг хэрэгжүүлэх боломжтой байдлаар хамтран ажиллах.

20.1.1. Ойрын ирээдүйд төлөвлөгдөж буй хамтын ажиллагаатай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлийн хүчин зүйлс (хууль эрх зүйн, зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, кастодианы, үйл ажиллагааны эрсдэлийн гэх мэт)-ийг тодорхойлох ямар арга хэрэгсэл ашигладаг вэ? Хамтын ажиллагаа тогтоох эсэх тухай дэд бүтцийн шийдвэрт хэрхэн нөлөөлдөг вэ?

20.1.2. Бусад дэд бүтэцтэй ямар хамтын ажиллагаа тогтоогоод байна вэ? Дэд бүтэц нь хамтын ажиллагаатай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлийг хэрхэн тогтмол тодорхойлж, хянаж, удирддаг вэ?

20.1.3. Бусад зарчмын хэрэгжилтийг хангах боломжтой байдлаар хамтын ажиллагааг тогтоосон болохыг дэд бүтэц нь хэрхэн нягталдаг вэ? Энэ дүн шинжилгээг хэр тогтмол хийдэг вэ?

Гол асуудал 2. Хамтын ажиллагаа нь түүний бүтэц хэлбэрийг дэмжсэн, дэд бүтцүүдийн эрх ашгийг бүрэн дүүрэн хамгаалсан хууль, эрх зүйн сайн үндэслэлтэй байх.

20.2.1. Дэд бүтэц нь ямар улс оронд хамтын ажиллагаа тогтоогоод байна вэ? Энэ хамтын ажиллагааг дэмжсэн хууль, эрх зүйн орчин хэр бүрдсэн бэ?

20.2.2. Хамтын ажиллагааны хууль, эрх зүйн үндэслэл нь түүний бүтэц хэлбэрийг дэмжсэн, дэд бүтцүүдийн эрх ашгийг сайтар хамгаалж буй болохыг хэрхэн нягталдаг вэ? Эрх зүйн ийм хамгаалалт нь цаашид үр дүнтэй байх боломжийг дэд бүтэц нь хэрхэн бүрдүүлсэн вэ?

Гол асуудал 3. Хамтын ажиллагаа бүхий ҮЦТХТ-үүд нь нэг нэгнийхээ үйл ажиллагаатай холбоотой зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг үнэлж, хянаж, удирдах. ҮЦТХТ-үүд хоорондын аливаа нэмэлт зээл нь найдвартай барьцаа хөрөнгөөр бүрэн баталгаажсан, зээлийн хязгаартай нийцсэн байх.

20.3.1. Хамтын ажиллагаатай холбоотой зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг үнэлж, хянаж, удирдах газар дээрх ямар арга хэрэгсэл, зохицуулалттай вэ?

20.3.2. Хэрэв ҮЦТХТ нь хамтран ажиллаж буй ҮЦТХТ-дээ зээл олгох механизмтай бол нэмэлт зээлээ найдвартай барьцаа хөрөнгөөр баталгаажуулж, зээлийн хязгаартай нийцүүлэн олгосон эсэхийг ямар арга хэрэгсэл хянадаг вэ?

Гол асуудал 4. Хамтын ажиллагаа бүхий ҮЦТХТ-дийн хооронд үнэт цаасыг нөхцөл дурдан шилжүүлэхийг хориглох, тийм боломжгүй тохиолдолд наад зах нь тухайн шилжүүлэг амжилттай болохоос өмнө тэдгээр үнэт цаасыг дахин шилжүүлэхийг хориглох.

20.4.1. Хамтын ажиллагааны хүрээнд үнэт цаасыг нөхцөл дурдан шилжүүлэх боломжтой юу? Хэрэв тийм бол ямар зохицуулалтын хүрээнд ийм шилжүүлэг хийх шаардлага үүсдэг вэ? Эхний шилжүүлэг амжилттай хийгдтэл тэдгээр үнэт цаасыг дахин шилжүүлэхийг хориглосон уу?

Гол асуудал 5. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа бүхий ҮЦТХТ-ийн хувьд оролцогчдын бүрэн эрх сайтар хамгаалагдсан тохиолдолд л зөвхөн үнэт цаас гаргагч ҮЦТХТ-тэй хамтын ажиллагаа тогтоох.

20.5.1. Хамтын ажиллагаатай холбоотойгоор оролцогчдын бүрэн эрх сайтар хамгаалагдаж байгаа болохыг хэрхэн тодорхойлдог вэ?

20.5.2. Кастодианд үнэт цаас хадгалуулж буй хуулийн этгээд нь эзэмшлийн бүртгэлтэй холбоотой тохируулгыг хэр тогтмол хийдэг вэ?

20.5.3. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа бүхий ҮЦТХТ-ийн хувьд оролцогчдын бүрэн эрх (төвлөрсөн дансан дахь хөрөнгийг тус тусад нь бүртгэх болон шилжүүлэх)-ийг хэрхэн хамгаалдаг вэ ?

Гол асуудал 6. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа бүхий ҮЦТХТ нь үнэт цаас гаргагч ҮЦТХТ-тэй хамтын ажиллагаа тогтоохдоо зуучлагч байгууллагаар дамжуулж байгаа бол тухайн зуучлагчтай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэл (кастодианы, зээлийн, хууль зүйн, үйл ажиллагааны эрсдэл)-ийг үнэлж, хянах, удирдах.

20.6.1. Хэрэв ҮЦТХТ нь хамтын ажиллагаа тогтоохдоо зуучлагчид хандаж байгаа бол зуучлагчийг сонгохдоо ямар шалгуур тавьж байна вэ? Эдгээр шалгуур нь эрсдэлд суурилсан уу?

20.6.2. Хамтын ажиллагаа тогтоож буй ҮЦТХТ-үүд болон зуучлагч байгууллага ямар үүрэг хариуцлага хүлээж байна вэ?

20.6.3. Зуучлагчтай холбоотой болзошгүй эрсдэлийг үнэлж, хянаж, удирдах ямар арга хэрэгсэлтэй вэ?

Гол асуудал 7. Өөр бусад АКТ-тэй хамтын ажиллагаа тогтоохын өмнө АКТ нь тухайн АКТ үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүсэж болзошгүй үр дагаврыг тодорхойлж удирдах. Хэрэв хамтын ажиллагаа нь 3 ба түүнээс дээш АКТ-ийг хамарч байгаа бол АКТ бүр олон талт хамтын ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлж, үнэлж, удирдах.

Хамтран ажиллаж буй АКТ үүргээ биелүүлэх боломжгүй болох

20.7.1. АКТ нь өөр бусад АКТ-тэй хамтын ажиллагаа тогтоохын өмнө тухайн АКТ үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүсэж болзошгүй үр дагаврыг тодорхойлж, үнэлэх ямар дүн шинжилгээ хийдэг бэ?

20.7.2. Хамтран ажиллаж буй АКТ үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүссэн үр дагаврыг АКТ нь хэрхэн удирддаг вэ?

Олон талт хамтын ажиллагааны зохицуулалт (3 ба түүнээс дээш АКТ)

20.7.3. АКТ нь 3 ба түүнээс дээш АКТ-тэй хамтын ажиллагаа тогтоохын өмнө олон талт хамтын ажиллагаанаас үүсэж болзошгүй үр дагаврыг тодорхойлж, үнэлэх ямар дүн шинжилгээ хийдэг бэ?

20.7.4. АКТ нь олон талт хамтын ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлийг тодорхойлж, хянаж, удирдах ямар арга хэрэгсэл ашигладаг вэ? Хамтын ажиллагаатай холбоотойгоор АКТ бүрийн эрх, үүргийг тодорхой тодорхойлж өгсөн үү?

Гол асуудал 8. Бусад АКТ-тэй хамтын ажиллагаа бүхий АКТ-ийн хувьд оролцогчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхаа сулруулахгүйгээр хамтран ажиллаж буй АКТ болон оролцогчдодоо учруулж буй одоогийн, ирээдүйн болзошгүй эрсдэлийг найдвартай удирдах боломжтой байх.

Болзошгүй эрсдэл, түүнээс хамгаалах нь

20.8.1. Хамтран ажиллаж буй АКТ-тэй холбоотой эрсдэлийг үнэлж, хянаж, удирдах ямар арга хэрэгсэлтэй вэ?

20.8.2. АКТ нь үүссэн эрсдэлээс бүрэн дүүрэн хамгаалах боломжийг хэрхэн тогтмол хангадаг вэ?

20.8.3. АКТ нь хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхаа сулруулахгүйгээр ирээдүйн болзошгүй эрсдэлээс бүрэн дүүрэн хамгаалах боломжийг хэрхэн хангасан бэ?

Эрсдэлийн удирдлага

20.8.4. АКТ нь хамтын ажиллагаанаас үүдэлтэй эрсдэлийг удирдах газар дээрх ямар арга хэрэгсэлтэй вэ?

20.8.5. Хэрэв АКТ нь хамтран ажиллаж буй АКТ-дөө хөрөнгийн шаардлагыг хангах тал дээр дэмжлэг үзүүлдэг бол энэ нь оролцогчдынхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд нөлөөлөхгүй болохыг нягталдаг вэ?

Оролцогчдыг мэдээллээр хангах

20.8.6. Хамтран ажиллаж буй АКТ-үүд нь уялдаа холбоо бүхий ажиллагаанд оролцогч бүрийн бусдадаа учруулж болзошгүй үүссэн нөхөн төлөгдөөгүй хохирол, алдагдал болон төлбөрийн чадварын дутагдал зэргээс үүдэн гарах эрсдэлээ мэдэгдэж буй эсэхийг хэрхэн баталгаажуулдаг вэ?

Гол асуудал 9. Мэдээллийн технологийн хүчин чадал, найдвартай байдал, холбогдох бусад нөөц бололцоог хангах үүднээс АМС нь хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны бусад эрсдэлийг нарийвчлан үнэлэх.

20.9.1. Бусад дэд бүтэцтэй тогтоосон хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны бусад эрсдэлд анхаарал хандуулахын тулд АМС нь мэдээллийн технологийн хүчин чадал, найдвартай байдал, холбогдох бусад нөөц бололцоог хэрхэн хангадаг вэ?

Зарчим 21. Үр ашигтай ба үр дүнтэй байдал

Дэд бүтэц нь оролцогчдын болон тухайн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахдаа үйл ажиллагааныхаа үр ашигтай, үр дүнтэй байдлыг хадгална.

Гол асуудал 1: Клиринг, төлбөр тооцоо хийх зохицуулалт, үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, ямар бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр тооцоо, клирингийг гүйцэтгэх буюу бүртгэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, техник, технологийн ашиглалт зэрэг асуудлууд дээр оролцогчдын болон тухайн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдсэн байх.

21.1.1. Клиринг, төлбөр тооцоо хийх зохицуулалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, ашиглаж буй систем, техник технологи, үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэг асуудлууд дээр оролцогчдын болон тухайн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж буй эсэхийг хэрхэн тодорхойлдог вэ?

21.1.2. Оролцогчдын болон бусад хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх, цаашид хангаж чадах эсэхийг хэрхэн тодорхойлдог вэ?

Гол асуудал 2: Үйлчилгээний ерөнхий цар хүрээ ямар байх, эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг яаж хөгжүүлэх зэрэг үнэлж дүгнэж, хүрч болохуйц тодорхой зорилго, зорилттой байх.

21.2.1. Үйл ажиллагааныхаа үр дүнтэй уялдуулан ямар зорилго, зорилт дэвшүүлээд байна бэ?

21.2.2. Үнэлж дүгнэж, хүрч болохуйц тодорхой зорилго, зорилт дэвшүүлсэн гэдгээ хэрхэн илэрхийлэх вэ?

21.2.3. Тэдгээр зорилго, зорилтдоо хэр зэрэг хүрч байна вэ? Үүнийг үнэлж, дүгнэх ямар механизм байна вэ?

Гол асуудал 3: Үйл ажиллагааныхаа үр ашигтай, үр дүнтэй байдлыг тогтмол үнэлж, дүгнэх тогтсон механизмтай байх.

21.3.1. Үйл ажиллагааныхаа үр ашигтай, үр дүнтэй байдлыг үнэлэхэд ямар арга хэрэгсэл, хэмжигдэхүүн хэрэглэдэг вэ?

21.3.2. Үйл ажиллагааныхаа үр ашигтай, үр дүнтэй байдлыг хэр тогтмол үнэлдэг вэ?

Зарчим 22. Мэдээлэл харилцаа холбооны стандарт, горим

Дэд бүтэц нь төлбөр тооцоо, клиринг, бүртгэлийн үйл ажиллагааныхаа үр ашигтай байдлыг хангахын тулд мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, горимуудыг ашиглах буюу тэдгээрт нийцэн ажиллах шаардлагатай.

Гол асуудал 1: Мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, горимуудыг үйл ажиллагаандаа ашиглах буюу тэдгээрт нийцэн ажиллах.

Мэдээлэл харилцаа холбооны горимууд

22.1.1. Мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн горимуудыг үйл ажиллагаандаа ашигладаг уу, тийм бол ямар горимуудыг ашигладаг вэ? Хэрэв ашигладаггүй бол тэдгээр горимуудад хэрхэн зохицож ажилладаг вэ?

22.1.2. Хил дамнасан төлбөр тооцоо боловсруулдаг бол хил дамнасан үйл ажиллагааны хувьд мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн горимуудыг үйл ажиллагаа, системдээ хэрхэн ашигладаг эсхүл тэдгээрт хэрхэн нийцэн ажилладаг вэ?

Мэдээлэл харилцаа холбооны стандартууд

22.1.3. Мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг үйл ажиллагаандаа ашигладаг уу, тийм бол ямар стандартыг ашигладаг вэ? Хэрэв ашигладаггүй бол тэдгээр стандартад хэрхэн нийцэн ажилладаг вэ?

22.1.4. Хил дамнасан төлбөр тооцоо боловсруулдаг бол хил дамнасан үйл ажиллагааны хувьд мэдээлэл харилцаа холбооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг үйл ажиллагаа, системдээ хэрхэн ашигладаг эсхүл тэдгээрт хэрхэн нийцүүлэн ажилладаг вэ?

22.1.5. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ямар нэгэн стандарт ашигладаггүй бол олон улсын стандартын дагуу боловсруулагдсан мессэж, мэдээллийг систем рүүгээ хөрвүүлэх тохиргоо хэрхэн хийдэг вэ?

Зарчим 23. Дүрэм, журам, мэдээллийн ил тод байдал

Дэд бүтэц нь тодорхой, цогц дүрэм, журамтай байх шаардлагатай бөгөөд оролцогчдод учирч болзошгүй эрсдэл, үйлчилгээний шимтгэл, хураамж болон бусад томоохон зардлын талаарх үнэн зөв ойлголт өгөх үүднээс хангалттай мэдээллээр хангана. Түүнчлэн, холбогдох дүрэм, журмуудыг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах.

Гол асуудал 1. Оролцогчдод ил тод, тодорхой, цогц дүрэм, журамтай байх. Түүнчлэн, холбогдох дүрэм, журмуудыг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах.

Дүрэм, журмууд

23.1.1. Үйл ажиллагааныхаа дүрэм, журмуудыг ямар баримт бичигт тусгасан вэ? Тэдгээрийг оролцогчдод хэрхэн ил тод болгодог вэ?

23.1.2. Тэдгээр дүрэм, журмаа тодорхой, ойлгомжтой эсэхийг хэрхэн тодорхойлдог вэ?

Ил тод байдал

23.1.3. Дүрэм, журамдаа урьдчилан тооцоолсон гэнэтийн нөхцөл байдалд дагаж мөрдөх процедурын талаар ямар мэдээлэл тусгасан бэ?

23.1.4. Дүрэм, журамдаа өөрчлөлт оруулахад баримтлах процедурын талаар хэнд, хэрхэн мэдээлдэг вэ?

23.1.5. Холбогдох дүрэм, журмыг олон нийтэд хэрхэн нээлттэй, ил тод болгодог вэ?

Гол асуудал 2. Болзошгүй эрсдэлийг үнэлэх боломж олгох үүднээс оролцогчдыг системийн бүтэц, үйл ажиллагаа, талуудын эрх, үүргийн талаарх мэдээллээр хангах.

23.2.1. Системийн бүтэц, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ямар баримт бичгүүдэд тусгасан бэ? Системийн загвар дизайн, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэнд, хэрхэн өгдөг вэ?

23.2.2. Системийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөхүйц томоохон шийдвэрүүдийг хэрэгжүүлэхдээ энэ талаар хэнд, хэрхэн анхааруулдаг вэ?

23.2.3. Оролцогчдод тэдний эрх, үүрэг, болзошгүй эрсдэлүүдийн талаар ямар мэдээлэл өгдөг вэ?

Гол асуудал 3. Үйл ажиллагааны дүрэм, журам болон учирч болзошгүй эрсдэлүүдийн талаарх оролцогчдынхоо ойлголтыг бэхжүүлэхийн үүднээс бүхий л шаардлагатай баримт материалаар хангаж, сургалт хөтөлбөр зохион байгуулах.

23.3.1. Үйл ажиллагааныхаа дүрэм, журам, холбогдох эрсдэлүүдийн талаарх оролцогчдынхоо ойлголтыг хэрхэн бэхжүүлдэг вэ?

23.3.2. Тэдгээр арга хэрэгслээрээ дүрэм, журам, болзошгүй эрсдэлүүдийн талаарх оролцогчдынхоо ойлголтыг бэхжүүлдэг гэдгийг нотлох баримт материал байна уу?

20.3.3. Тухайн оролцогч дүрэм, журам, болзошгүй эрсдэлийн талаар өнгөц ойлголттой байгаа болохыг олж тогтоосон бол үүнтэй холбогдуулан ямар арга хэмжээ авдаг вэ?

Гол асуудал 4. Үйлчилгээний шимтгэл, хураамж болон боломжит хөнгөлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгох. Түүнчлэн, үнийн харьцуулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төлбөртэй үйлчилгээний талаар тодорхой мэдээллээр хангах.

23.4.1. Үйлчилгээ бүрийнхээ шимтгэл, хураамж болон боломжит хөнгөлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэдэг вэ?

23.4.2. Үйлчилгээ болон шимтгэл, хураамжид өөрчлөлт ороход холбогдох мэдээллийг оролцогчид болон олон нийтэд хэрхэн өгдөг вэ?

23.4.3. Төлбөртэй үйлчилгээний талаарх мэдээллээр хангадаг уу? Тэдгээр мэдээллийг ашиглан бусад ижил төрлийн төлбөр тооцооны системийн шимтгэл, хураамжтай харьцуулалт хийх боломжтой юу?

23.4.4. Үйл ажиллагааны зардалд нөлөөлөхүйц технологи, харилцаа холбооны горимууд болон холбогдох бусад хүчин зүйлсийн талаарх мэдээлэл нээлттэй, ил тод уу?

Гол асуудал 5. ОУТТБ болон ҮЦХОУБ-гаас гаргасан “СЗЗДБ-ийн ил тод байдлын тайлан”-г тогтмол гаргаж, олон нийтэд толилуулах. Түүнчлэн, гүйлгээний тоо, дүнгийн талаарх ерөнхий мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгох.

23.5.1. “СЗЗДБ-ийн ил тод байдлын тайлан”-г хамгийн сүүлд хэзээ гаргасан бэ? Тайлангаа хэр тогтмол шинэчилдэг вэ? Системийн болон орчны томоохон өөрчлөлтийн дараагаар дээрх тайланг хамгийн багадаа 2 жил тутамд шинэчлэн гаргадаг уу?

23.5.2. Олон нийтийг ямар тоон мэдээллээр хангадаг вэ? Энэ мэдээллээ хэр тогтмол шинэчилдэг вэ?

23.5.3. Олон нийтийг өөр ямар мэдээллээр хангадаг вэ?

23.5.4. Эдгээр мэдээллээ олон нийтэд хэрхэн, ямар хэл дээр хүргэдэг вэ?

Зарчим 24. АМС дахь мэдээллийн ил тод байдал

АМС нь холбогдох эрх бүхий байгууллага, олон нийтийг тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, цагаа олсон, үнэн зөв мэдээллээр хангана.

Гол асуудал 1: АМС нь зах зээлийн ил тод байдлыг сайжруулах, нийгмийн бусад бодлогын зорилго, зорилтыг дэмжих үүднээс холбогдох эрх бүхий байгууллага, олон нийтийг зохицуулалтын болон салбарын хүлээлттэй нийцсэн, иж бүрэн, нарийвчилсан мэдээллээр хангах.

24.1.1. Холбогдох эрх бүхий байгууллага, олон нийтийг ямар мэдээллээр хангах боломжтой вэ?

24.1.2. Мэдээлэл холбогдох эрх бүхий байгууллага, олон нийтийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж буй эсэхийг хэрхэн нягталдаг вэ?

Гол асуудал 2: Холбогдох эрх бүхий байгууллагад зохицуулалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжийг олгох үүднээс АМС нь тэднийг холбогдох мэдээллээр тухай бүр хангах үр дүнтэй арга хэрэгсэлтэй байх.

24.2.1. Холбогдох эрх бүхий байгууллагад зохицуулалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжийг олгох үүднээс тэднийг тухай бүр мэдээллээр хангах ямар арга хэрэгсэл байна вэ?

24.2.2. Холбогдох эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах үйл явц нь хууль, эрх зүй, үйл ажиллагаа, технологийн талаас дэмжигдэж буй эсэхэд хэрхэн анхаардаг вэ?

Гол асуудал 3: АМС нь тухайн үеийн болон түүхэн үнэн зөв мэдээллээр хангах мэдээллийн найдвартай системтэй байх. Мэдээллийг дүн шинжилгээ хийхэд хялбар хэлбэрээр тухай бүр өгдөг байх.

24.3.1. Мэдээллийн үнэн зөв байдлыг хэрхэн хангадаг вэ?

24.3.2. Тоон болон бусад төрлийн мэдээллийг шинжилгээ, судалгаа, харьцуулалт хийхэд дөхөмтэй хэлбэрээр өгч буй эсэхэд хэрхэн анхаарал хандуулдаг вэ?

_____оОо_____